

ОЛИМПИЙН ХАРТИ

2011 оны 07-р сараас хүчинтэй

Олон Улсын Олимпийн Хороо

Chateau de Vidy – C6P6356 – CH-1007 Lausanne/Switzerland

Tel: +41 21 621 6111 Fax: +41 21 621 6216

www.olympic.org

2011 оны 07 сард Олон Улсын Олимпийн Хорооноос бэлтгэн гаргав.
Зохиогчын эх хуулиар хамгаалагдсан болно.

Швейцарь улсын Лозаннь, хотын DidWeDo S.a.r.l –д хэвлэн гаргав.

Орчуулсан: Ч.АМАРСАНАА / МҮОХ-ны гишүүн, МШТХ-ны Е/н/б/дарга /

Хянан тохиолдуулсан: Ж.ОТГОНЦАГААН / МҮОХ-ны Е/н/б/дарга /

ГАРЧИГ

| | |
|--|----|
| Олимпийн хөдөлгөөнд хэрэглэгдэх товчилсон хэллэг | 7 |
| Олимпийн Хартын талаархи танилцуулга | 8 |
| Удиртгал | 9 |
| Олимпизмийн Үндсэн Зарчимууд | 10 |

Бүлэг 1

ОЛИМПИЙН ХӨДӨЛГӨӨН

13

| | |
|---|----|
| 1. Олимпийн хөдөлгөөн түүний бүтэц, бүрэлдэхүүн хэсэг..... | 13 |
| 2. ОУОХ-ний эрхэм зорилго, гүйцэтгэх үүрэг* | 14 |
| Дүрмийн 2-д хамаарах заалтууд | 15 |
| 3. ОУОХ-ноос хүлээн зөвшөөрөх нь..... | 16 |
| 4. Олимпийн Конгресс* | 17 |
| Дүрмийн 4-д хамаарах заалтууд | 17 |
| 5. Олимпийн эв санааны нэгдэл* | 17 |
| Дүрмийн 5-д хамаарах заалтууд | 18 |
| 6. Олимпийн Наадам* | 19 |
| Дүрмийн 6-т хамаарах заалтууд | 19 |
| 7. Олимпийн Наадам, Олимпийн өмч, эд хөрөнгийн талаар эдлэх эрх*..... | 19 |
| 8. Олимпийн бэлэгдэл* | 20 |
| 9. Олимпийн далбаа*..... | 21 |
| 10. Олимпийн уриа лоозон* | 21 |
| 11. Олимпийн эмблемүүд *..... | 21 |
| 12. Олимпийн дуулал* | 22 |
| 13. Олимпийн гал, Олимпийн бамбарууд*..... | 22 |
| 14. Олимпийн холбогдолтой дүрс бичлэг..... | 22 |
| Дүрмийн 7-д хамаарах заалтууд | 22 |

БҮЛЭГ 2

ОЛОН УЛСЫН ОЛИМПИЙН ХОРОО (ОУОХ)29

| | |
|--------------------------------------|----|
| 15. Хууль Эрх зүйн хэмжээ..... | 29 |
| 16. Гишүүд* | 30 |
| Дүрмийн 16-д хамаарах заалтууд | 34 |
| 17. Бүтэц, зохион байгуулалт | 38 |
| 18. Чуулган* | 39 |
| Дүрмийн 18-д хамаарах заалтууд | |
| 19. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл* | 42 |
| Дүрмийн 19-д хамаарах заалтууд | 44 |
| 20. Ерөнхийлөгч* | 45 |
| Дүрмийн 20-д хамаарах заалтууд | 46 |
| 21. ОУОХ-ны Хороодууд* | 46 |
| Дүрмийн 21-д хамаарах заалтууд..... | 46 |
| 22. ОУОХ-ны Ёс зүйн хороо* | 48 |
| Дүрмийн 22-д хамаарах заалтууд | 49 |
| 23. Албан ёсны хэл | 49 |
| 24. ОУОХ-ны хөрөнгө, санхүү..... | 49 |

БҮЛЭГ 3

ОЛОН УЛСЫН СПОРТЫН ХОЛБООД (ОУСХ)51

| | |
|--|----|
| 25. ОУСХ-дыг албан ёсоор хүлээн зөвшөөрөх нь..... | 51 |
| 26. Олимпийн хөдөлгөөн дахь ОУСХ-дийн эрхэм зорилго, гүйцэтгэх үүрэг | 52 |

БҮЛЭГ 4

ҮНДЭСНИЙ ОЛИМПИЙН ХОРООД (ҮОХд)55

| | |
|---|----|
| 27. ҮОХ-дын эрхэм зорилго, гүйцэтгэх үүрэг* | 55 |
|---|----|

| | |
|---|----|
| 28. ҮОХ-дын бүтэц, бүрэлдхүүн* | 57 |
| Дүрмийн 27 болон 28-д хамаарах заалтууд | 59 |
| 29. Үндэсний Спортын Холбоод | 61 |
| 30. ҮОХ-дийн нэр, улс | 62 |
| 31. ҮОХ-дийн далбаа, эмблэм, дуулал | 62 |

БҮЛЭГ 5

ОЛИМПИЙН НААДАМ

I. Олимпийн Наадмыг удирдах, зохион байгуулах, тэмдэглэх65

| | |
|--|----|
| 32. Олимпийн Наадмыг тэмдэглэх, зохион байгуулах* | 65 |
| Дүрмийн 32-д хамаарах заалтууд | 65 |
| 33. Олимпийн Наадмыг зохион байгуулах хотыг сонгон шалгаруулах* | 66 |
| Дүрмийн 33-д хамаарах заалтууд | |
| 34. Олимпийн Наадмыг зохион явуулах газар, байгууламж* | 68 |
| Дүрмийн 34-д хамаарах заалтууд | |
| 35. Зохион байгуулах хороо* | 69 |
| Дүрмийн 35-д хамаарах заалтууд | |
| 36. Үүрэг хариуцлага – Олимпийн наадмыг зохион байгуулах эрхийг цуцлах нь... | |
| 37. Олимпийн наадмыг зохицуулах хороо-ҮОХ болон ЗБХороо хоорондын ажлын уялдаа холбоо* | |
| Дүрмийн 37-д хамаарах заалтууд | |
| 38. Олимпийн тосгон * | |
| Дүрмийн 38-д хамаарах заалтууд | |
| 39. Соёлын хөтөлбөр | |

II. ОЛИМПИЙН НААДАМД ОРОЛЦОХ НЬ

| | |
|--------------------------------|--|
| 40. Оролцох журам* | |
| Дүрмийн 40-д хамаарах заалтууд | |

41. Оролцогчдын иргэний харъяалал*

Дүрмийн 41-д хамаарах заалтууд

42. Насны хязгаар*

Дүрмийн 42-д хамаарах заалтууд

43. Дэлхийн сэргээшийн эсрэг дүрэм

44. Урилга ба оролцох мэдүүлэг*

Дүрмийн 44-д хамаарах заалтууд

III. ОЛИМПИЙН НААДМЫН ХӨТӨЛБӨРҮҮД

45. Олимпийн наадмын хөтөлбөр*

Дүрмийн 45-д хамаарах заалтууд

46. Олимпийн наадамд ОУСХ-дод ноогдох мэргэжил, техникийн хариуцлага*

Дүрмийн 46-д хамаарах заалтууд

47. Залуучуудын зуслан*

Дүрмийн 47-д хамаарах заалтууд

48. Олимпийн наадмыг зурагт, хэвлэл мэдээлэлээр сурталчилах нь*

Дүрмийн 48-д хамаарах заалтууд

49. Олимпийн наадмыг хэвлэлээр нийтлэх нь*

Дүрмийн 49-д хамаарах заалтууд

50. Зар сурталчилгаа, суртал ухуулга*

Дүрмийн 50-д хамаарах заалтууд

IV. ПРОТОКОЛ

51. Протокол

52. Олимпийн наадмын үнэмлэх, нэвтрэх зөвшөөрлийн карт

53. Олимпийн далбааг хэрэглэх явц

54. Олимпийн галыг хэрэглэх явц

55. Нээлт болон хаалтын ажиллагаа

56. Диплом, медаль, шагнал гардуулах ёслолын ажиллагаа

57. Шагналтуудын нэрсийн жагсаалт

БҮЛЭГ 6

Арга хэмжээ, шийтгэл, сахилгын дүрэм, маргаан шийдвэрлэх

59. Арга хэмжээ, шийтгэл*

60. Маргаан шийдвэрлэх

61. ОУОХ-ны шийдвэрийг давж заалдах нь

*Дүрэмд хамаарах заалтууд байгааг илэрхийлнэ.

Олимпийн хөдөлгөөнд хэрэглэгдэх товчлол

ОУОХ Олон Улсын Олимпийн Хороо

ОХ Олимпийн Харт

Р... Олимпийн Хартын ...р дүрэм

Дхз... Олимпийн Хартын Дүрмийн ... -д хамаарах заалтууд

| | |
|--------|--|
| ОНЗБХ | Олимпийн Наадмыг зохион байгуулах хороо |
| ОУХ | Олон Улсын Спортын Холбоо |
| ОУЗСХЗ | Олон улсын зуны спортын холбоодын зөвлөл |
| ОУӨСХЗ | Олон улсын өвлийн спортын холбоодын зөвлөл |
| ҮОХ | Үндэсний Олимпийн Хороо |
| ОУПОХ | Олон Улсын Параолимпийн Холбоо |
| ҮОХЗ | Үндэсний Олимпийн Хороодын Зөвлөл |
| АҮОХЗ | Африкийн Үндэсний Олимпийн Хороодын Зөвлөл |
| АОЗ | Азийн Олимпийн Зөвлөл |
| ПАСХ | Пан-Америкийн Спортын Хороо |
| АНДҮОХ | Ази Номхон Далайн Үндэсний Олимпийн Хороо |
| ЕОЗ | Европын Олимпийн Зөвлөл |
| САШ | Спортын Арбитрын Шүүх |
| ОУСЭА | Олон Улсын Сэргээшийн эсрэг агентлаг |
| ОУОА | Олон Улсын Олимпийн Академи |

Олимпийн хөдөлгөөнд хэрэглэгдэх товчлол

| | |
|--------|------------------------------------|
| IOC | International Olympic Committee |
| OC | Olympic Charter |
| R... | Olympic Charter Rule... |
| BLR... | Olympic Charter Bye-Law to Rule... |

| | |
|-------|--|
| OCOG | Organising Committee of the Olympic Games |
| IF | International Federation |
| ASOIF | Association of Summer Olympic International Federations |
| AIOWF | Association of the International Olympic Winter Sports Federations |
| NOC | National Olympic Committee |
| IPC | International Paralympic Committee |
| ANOC | Association of National Olympic Committees |
| ANOCA | Association of National Olympic Committees of Africa |
| OCA | Olympic Council of Asia |
| PASO | Pan-American Sports Organisation |
| ONOC | Oceania National Olympic Committees |
| EOC | The European Olympic Committees |
| CAS | Court of Arbitration for Sport |
| OGKM | Olympic Games Knowledge Management Programme |
| WADA | World Anti-Doping Agency |
| IOA | International Olympic Academy |

Олимпийн Хартын талаархи танилцуулга

Олимпийн Харт /ОХ/ нь Олон Улсын Олимпийн Хорооноос /ОУОХ/ Олимпийн хөдөлгөөн түүний үндсэн зарчим, дүрэм, заалтуудыг хуульчлан батлан гаргасан баримт бичиг мөн. Энэхүү баримт бичиг нь Олимпийн хөдөлгөөн түүний бүтэц, үйл ажиллагааг удирдан чиглүүлж Олимпийн Наадмыг зохион байгуулах, ёслон тэмдэглэх удирдамж болно.

Олимпийн Харт нь дараахь үндсэн гурван зорилгоор хэрэглэгдэнэ:

А. Олимпийн Харт нь Олимпизм түүний үнэт зүйлс, үндсэн зарчимуудыг тодорхойлон сануулж, дагаж мөрдөхөд

Б. Олимпийн Харт нь Олон Улсын Олимпийн Хорооны хуульчилсан албан бичиг болоход

В. Олимпийн Харт нь Олимпийн Хөдөлгөөний үндсэн гурван бүрэлдхүүн хэсэг болох Олон улсын олимпийн хороо, Олон улсын спортын холбоод, Үндэсний олимпийн хороод болон Олимпийн Наадмыг зохион байгуулах хорооны эрх, үүрэгийг тодорхойлж түүнийг дагаж мөрдөхөд тус тус хэрэглэгдэнэ.

Тайлбар:

Олимпийн Хартанд ерөнхийлөгч, дэд-ерөнхийлөгч, дарга, гишүүн, багийн ахлагч, албаны хүн, тамирчин, дасгалжуулагч, шүүгч гэх мэт хувь хүн болон хүмүүсийг тухайлан тодорхойлж бичээгүй бол эр болон эм хүйсээр нь ялган ойлгоно.

Олимпийн Хартанд тухайлан бичээгүй бол 1-р сарын 1-ны өдрөөс 12-р сарын 31-ны өдрийг дуустал НЭГ жил буюу хуанлийн жил гэж ойлгоно.

УДИРТГАЛ

Пеир Де Кубертин нь орчин үеийн Олимпизмийн үзэл санааг үндэслэгч бөгөөд түүний санаачлагаар 1894 оны 06 сард анхны Олон Улсын Тамирчдын Конгресс Парис хотод болсон. Улмаар 1896 оны 06-р сарын 23 ны өдөр Олон Улсын Олимпийн Хороо байгуулагдсан. Орчин үеийн Олимпийн анхдугаар Наадам 1896 онд Грекийн Афин хотод зохион байгуулагдсан. 1914 оны Парисын Конгресс дээр Пеир Де Кубертин Олимпийн тугийг танилцуулж батлуулсан. Энэхүү туг нь Олимпийн наадмын үеэр уулзах таван тивийн тамирчдын эв нэгдэлийг илэрхийлсэн өөр хоорондоо холбоотой, хэлхээтэй таван цагирагаас бүрэлдэнэ. 1924 онд өвлийн олимпийн анхдугаар наадам Франц улсын Чамоникс хотод болсон.

Олимпизмийн Үндсэн Зарчимууд

1. Олимпизм нь хүний бие, сэтгэл, хүсэл зориг гэсэн чанаруудыг тэнцвэртэй хослуулан хөгжүүлэх, нэмэгдүүлэх амьдралын философи гүн ухаан юм. Олимпизм нь спортыг соёл болон боловсролтой хослуулан хүн төрөлхтний ёс суртахууны үндсэн зарчмуудыг хүндэтгэн баяр бахдал, аз жаргалтай амьдрах суурийг тавихад чиглэгдэнэ.
2. Олимпизмийн зорилго нь спортоор дамжуулан дэлхийд энх тайван байдлыг хангаж хүн төрөлхтөнийг эвтэй найрсаг хөгжин цэцэглэх боломж олгоход оршино.
3. Олимпийн хөдөлгөөн нь ОУОХ түүний удирдлага чиглэлийн дагуу Олимпизмийн үнэт зүйлс чанаруудыг дэмжигч байгуулага, хувь хүмүүсийн нэгдсэн зохион байгуулалттай, тасралтгүй авч хэрэгжүүлдэг үйл ажиллагаа юм. Энэ нь таван тивийг хамардаг. Энэхүү хөдөлгөөний оргил үе нь дэлхийн бүх тамирчдыг цугларуулсан спортын их баяр болох Олимпийн Наадам мөн. Үүний билэг тэмдэг нь хоорондоо холбоо бүхий таван цагираг юм.
4. Спортоор хичээллэх нь хүний эрх юм. Хүн бүр ямар нэгэн байдлаар ялгаварлан гадуурхагдахгүй спортоор хичээллэх боломжоор хангагдсан байх ёстой бөгөөд

Олимпийн үзэл санааны зарчмаар харилцан ойлголцож бие биенээ хүндэтгэн энхтайван, эв нэгдэлтэй шударгаар өрсөлдөх ёстой.

5. Аливаа нийгмийн хүрээнд спорт нь харин Олимпийн хөдөлгөөний хүрээнд спортын байгууллагууд нь өөрсдийн эрх үүрэгтэй бие даасан байдлаар оршин тогтнож ямар нэгэн гадны нөлөөлөлгүй спортын дүрэм журамаа батлан, спортын байгууллагаа байгуулж, чөлөөт сонгуулиар удирдах байгууллагаа байгуулж, хариуцлагатай сайн засаглалыг тогтоох нөхцлийг хүлээн зөвшөөрнө.
6. Хувь хүн болон тухайн улсыг арьсны үзэл, шашин, улс төр, хүйс зэрэг аливаа байдлаар ялгаварлан гадуурхах явдал нь Олимпийн Хөдөлгөөнд үл нийцнэ.
7. Олимпийн хөдөлгөөнд нэгдэн орохын тулд Олимпийн Хартын дагаж мөрдөхийн зэрэгцээ ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн байна.

ОЛИМПИЙН ХӨДӨЛГӨӨН

1. Олимпийн хөдөлгөөн түүний бүтэц, бүрэлдэхүүн хэсэг

1. Олон Улсын Олимпийн Хорооны бүрэн эрх, удирдлага чиглэлийн дагуу Олимпийн хөдөлгөөнд Олимпийн Хартыг хүлээн зөвшөөрч дагаж мөрддөг байгууллага, тамирчид, хувь хүмүүс нэгдэн ордог. Олимпийн хөдөлгөөний зорилго нь Олимпизм түүний үнэт зүйлс зарчимын дагуу спортоор дамжуулан залуу үеийнхэнд боловсрол олгож дэлхий дахинд энх тайван сайн сайхныг бий болгоход чиглэгддэг.
2. Олимпийн Хөдөлгөөний үндсэн гурван бүрэлдхүүн хэсэг нь Олон Улсын Олимпийн Хороо /ОУОХ/, Олон Улсын Спортын Холбоод /ОУСХ/, Үндэсний Олимпийн Хороод /ҮОХд / мөн.
3. Эдгээр үндсэн гурван бүрэлдхүүн хэсгээс гадна Олимпийн Хөдөлгөөнд Олимпийн тоглолтын зохион байгуулах хороо, үндэсний спортын холбоод, клубууд Олимпийн хөдөлгөөний чухал бүрэлдхүүн хэсэг болсон тамирчид, дасгалжуулагчид, шүүгчид, спортын албаны хүмүүс болон техникийн ажилчид хамрагдана. Мөн ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн бусад байгууллага болон институтууд хамрагдана.

4. Ямар нэгэн байдлаар Олимпийн хөдөлгөөнд нэгдэж байгаа аливаа байгууллага хувь хүмүүс нь Олимпийн Хартыг сахин биелүүлэх ёстой бөгөөд ОУОХ-ны шийдвэрийг мөрдөнө.

2. ОУОХ-ний эрхэм зорилго, гүйцэтгэх үүрэг

ОУОХ-ны эрхэм зорилго нь Дэлхий дахинд Олимпизмийг түгээн дэлгэрүүлж Олимпийн хөдөлгөөнийг удирдан чиглүүлэхэд оршино. ОУОХ-ны үүрэг нь:

1. Спортоор дамжуулан залуу үед боловсрол олгох, спортын зөв хариуцлагатай засаглал, ёс зүйг бий болгоход дэмжлэг үзүүлэх, спортын талбарт шударга өрсөлдөөн түүний үзэл санааг хэрэгжүүлэхэд хүч чармайлт гарган спорт дахь хүчирхийлэл, ёс бус зүйлийг хориглох, зогсоох
2. Спорт, спортын байгууллагуудыг хөгжин дэвших, тэмцээн уралдааныг зохион байгуулахад туслан дэмжих
3. Олимпийн наадмыг тогтмол ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх нөхцлөөр хангах
4. Спорт нь хүний сайн сайхны төлөө үйлчилж энэ нь улмаар энх тайван байдлыг хангах боломжтой гэсэн үүднээс чадамж чадвар бүхий төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран ажиллах
5. Олимпийн хөдөлгөөний эв нэгдэл нягтралыг сайжруулж түүний тусгаар тогтнолыг хамгаалах, спортын бие даасан байдлыг хангах
6. Олимпийн хөдөлгөөнд саад болох аливаа ялгаварлан гадуурах үзлийн эсрэг арга хэмжээ авах
7. Эр эм хүйсийн тэгш байх зарчмыг мөрдлөг болгон спортын бүх бүтэц, шатанд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар дэмжин туслах
8. Спорт дахь сэргээшийн эсрэг тэмцэх ажиллагааг манлайлах
9. Тамирчдын эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж үзүүлэхтэй холбоотой асуудлыг дэмжих, уриалах
10. Аливаа улс төрийн болон арилжааны зорилгоор тамирчид, спорт руу дайралт хийх, доромжлохын эсрэг тэмцэх

11. Тамирчдын ирээдүйн мэргэжил, нийгмийн асуудлыг хангах чиглэлээр хүч чармайлт гарган ажиллаж буй төрийн болон спортын байгууллагуудыг дэмжин туслах
12. Нийтийн биеийн тамир, спортын хөгжилийг хөхүүлэн дэмжих
13. Олимпийн Наадам болж байгаа газарт болон бусад газруудад байгаль орчны хариуцлагатай байдлыг дэмжин туслах, спортын тогтвортой хөгжлийг хөхүүлэн дэмжих
14. Олимпийн наадмаас дараагийн олимп болох хот, улсад эрхийг зөв журмаар шилжүүлэх
15. Спортыг соёл, боловсролтой хамтруулан хослуулж байгаа аливаа санал санаачлагыг дэмжин туслах
16. Олон Улсын Олимпийн академи болон Олимпийн боловсрол олгоход үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж буй аливаа байгууллагыг дэмжих

Дүрмийн 2-д хамаарах заалтууд:

1. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь ҮОХ-д болон ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн холбоодын хяналтын дор Олимпийн хартын нөхцөлүүдийн дагуу Олон улсын спортын холбоодын удирдамж, техникийн туслалцааг авч бүсийн, тивийн, дэлхийн хэмжээнд зохион байгуулагдаж буй олон улсын чанартай аливаа спортын наадам тоглолтыг дүрэм зааврын дагуу тохиромжтой гэж үзвэл ОУОХ-ноос дэмжлэг өгч болно.
2. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь ОУОХ-ны санхүүгийн дэмжлэг туслалцааг Олимпийн хөдөлгөөний зорилгыг биелүүлэхээр зохион байгуулагдаж буй бусад арга хэмжээнд өгч болно.

3. ОУОХ-ноос албан ёсоор хүлээн зөвшөөрөх нь

1. ОУОХ нь Олимпийн хөдөлгөөний бүрэлдхүүн хэсгүүдээ албан ёсоор хүлээн зөвшөөрнө.

2. ОУОХ нь өөрийн эрхэм зорилго, үүрэгтэй уялдаа холбоотой үйл ажиллагаа явуулдаг ҮОХ-дыг үндэсний спортын байгууллагууд гэж хүлээн зөвшөөрч болно. Түүнчлэн ОУОХ нь тивийн болон дэлхийн хэмжээнд зөвшөөрөгдсөн ҮОХ-дын нэгдсэн зөвлөлийг хүлээн зөвшөөрч болно. Бүх ҮОХ-д болон ҮОХ-нд хамаарах спортын холбоодууд нь боломжтой бол хуулийн этгээд байна. Тэд бүгд Олимпийн Хартыг дагаж мөрдөнө. Тэдгээрийн статус нь ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдөнө.
3. ОУОХ нь Олон улсын спортын холбоод болон Олон улсын спортын холбоодын нэгдсэн холбоог хүлээн зөвшөөрч болно.
4. ОУСХ-дын нэгдсэн холбоод мөн ҮОХ-дын нэгдсэн холбоодыг хүлээн зөвшөөрөх нь эдгээр холбоодын гишүүн бие даасан ОУСХ-д болон ҮОХ-дын ОУОХ-той шууд харилцах эсвэл ОУОХ-ноос тэдэнтэй шууд харилцах эрхэнд ямар ч нөлөөгүй байна.
5. ОУОХ нь Олимпийн Хартыг даган олон улсын түвшинд спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагыг хүлээн зөвшөөрч болно.
6. ОУОХ-нд хүлээн зөвшөөрөгдөх эсэх нь ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр шийдвэрлэгдэнэ.
7. ОХОУ-гоор хүлээн зөвшөөрөгдөх нь түр болон байнгын гэсэн ангилалтай байна. Тодорхой болон тодорхой бус хугацаагаар түр хүлээн зөвшөөрөгдөх эсвэл татгалзах эсэхийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл шийднэ. Түр хугацаагаар хүлээн зөвшөөрөх нөхцөл байдлыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл шийднэ. Байнгын орон тооны байдлаар хүлээн зөвшөөрөх түүний татгалзах асуудлыг Чуулганаар шийднэ. Хүлээн зөвшөөрөгдөх үйл явц, журамыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл тогтооно.

4. Олимпийн Конгресс

Олимпийн Конгресс нь Олимпийн Хөдөлгөөний бүрэлдхүүн хэсгүүдийн төлөөлөгчдийн хамарсан зөвлөлдөх уулзалт мөн. Конгресс нь зөвлөлдөх шинж чанартай бөгөөд ОУОХ-ны ерөнхийлөгч зарлан хуралдуулна. Конгресс хоорондын зайг ОУОХ тогтооно.

Дүрмийн 4-д хамаарах заалтууд:

1. Олимпийн Конгрессийг чуулганы /session/ шийдвэрээр ОУОХ-ны ерөнхийлөгч зарлан хуралдуулж ОУОХ зохион байгуулна. Конгресс болох газар болон өдрийг чуулганаар шийдвэрлэнэ. Конгрессийг Ерөнхийлөгч удирдан явуулна.
2. Олимпийн Конгресс нь ОУОХ-ны гишүүд, Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүд, өргөмжит гишүүд, ОУСХ-дын төлөөлөгчид болон ҮОХ-дын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Мөн ОУОХ-ноос хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагын төлөөлөгчид багтана. Үүний зэрэгцээ тамирчид, хувь хүмүүс урилгаар оролцож болно.
3. Олимпийн конгрессийн хөтөлбөрийг ОУСХ-д болон ҮОХ-дтой зөвлөлдсөний үндсэн дээр ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс батлан гаргана.

5. Олимпийн Эв санааны нэгдэл

Олимпийн эв санааны нэгдлийн зорилго нь ҮОХ-дод ялангуяа тусламж шаардлагатай байгаа ҮОХ-дод тусламжыг зохион байгуулахад чиглэгддэг. Энэхүү тусламж нь ОУОХ болон ҮОХ-дын сайтар боловсруулагдсан хөтөлбөрийн дагуу хэрэв шаардалгатай бол ОУСХ-доос техник, мэргэжлийн туслалцааг авч хэрэгжүүлдэг хөтөлбөр юм.

Дүрмийн 5-д хамаарах заалтууд:

Олимпийн Эв санааны нэгдлээс хэрэгждэг хөтөлбөрийн зорилтууд нь:

1. Олимпизмийн үндсэн зарчмуудыг дэмжих
2. ҮОХ-дыг Олимпийн Наадамд баг, тамирчдаа бэлтгэн оролцуулахад туслалцаа үзүүлэх
3. Тамирчид, дасгалжуулагчдын спортын мэргэжлийн мэдлэг чадварыг дээшлүүлэх

4. ҮОХ-д болон ОУСХ-той хамтарч ивээн тэтгэлэг болон бусад хэлбэрээр тамирчид, дасгалжуулагчдын мэргэжлийн түвшинг сайжруулах
5. Спортын салбарын удирдах ажилтан, зохион байгуулагчдыг бэлтгэх, дадлагажуулах
6. Олимпийн боловсрол олгох, спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор үйл ажиллагаа явуулж буй байгуулагуудтай хамтран ажиллах
7. Үндэсний болон олон улсын байгуулагуудтай хамтран шаардалгатай газарт энгийн, мэргэжлийн, хэмнэлттэй спортын байгууламж байгуулах
8. ҮОХ-дын зөвлөмжийн дагуу үндэсний, бүсийн болон тивийн хэмжээний спортын тэмцээн зохион байгуулахад туслах. Мөн бүсийн болон тивийн тоглолт наадамд төлөөлөгчдөө бэлтгэн оролцуулахад дэмжлэг туслалцаа үзүүлэх
9. ҮОХ-дын хоорондын хамтын ажиллагааг хөхүүлэн дэмжих
10. Засгийн газар болон ОУ-ын байгуулагуудыг албан ёсны хөгжлийн хөтөлбөртөө спортыг оруулахыг шаардах, ятгах

Олимпийн Эв санааны нэгдлийн хороо нь дээрхи бүх хөтөлбөрүүдийг удирдан хэрэгжүүлнэ.

6. Олимпийн Наадам*

1. Олимпийн наадам нь тамирчид хувийн болон багийн төрлөөр өөр хоорондоо өрсөлддөг тэмцээн, арга хэмжээ юм. Олимпийн наадамд ҮОХ-доос шилэгдсэн тамирчид ОУОХ-ноос хүлээн зөвшөөрөгдсөн тооны дагуу оролцдог. Тамирчид ОУСХ-дын мэргэжлийн заавар, дүрэм, удирдамжын дагуу өрсөлддөг.
2. Олимпийн наадам нь Олимпийн спортын төрлүүд болон өвлийн Олимпийн тоглолтоос бүрддэг. Өвлийн спортын төрөлд зөвхөн цас, мөсөн дээр хичээллэдэг төрлүүд хамаарна.

Дүрмийн 6-д хамаарах заалтууд:

1. Олимп нь 1-р сарын 1-нээс 12-р сарын 1-ныг хүртэлхи дөрвөн удаа тоологдсоны дараа буюу дөрвөн жил тутамд зохион байгуулагддаг.

2. Олимпийн наадам нь анх 1896 онд Афинд зохион байгуулагдсанаас хойш тоологдож байгаа бөгөөд 2012 онд XXX Олимп болно.
3. Өвлийн Олимпийн наадам анх зохион байгуулагдсанаас хойш мөн дэс дараалалтай тоологддож байгаа.

7. Олимпийн Наадам, Олимпийн өмч, эд хөрөнгийн талаар эдлэх эрх*

1. ОУОХ нь Олимпийн хөдөлгөөнийг удирдан чиглүүлэгчийнхээ тухайд ОУСХ-д болон ҮОХ-дыг Олимпийн наадамд баг тамирчдаа бэлтгэн оролцуулахад дэмжлэг үзүүлж, Олимпийн наадмыг зохион байгуулах, дэлгэрүүлэхэд хүчин чармайлт гарган материаллаг туслалцаа үзүүлэн Олимпийн хөдөлгөөн түүний үнэт зүйлсийг нэмэгдүүлэх, түгээх хариуцлагыг хүлээнэ. ОУОХ нь Олимпийн наадам болон энэхүү дүрэмд тусгагдсан орлого олох боломж бүхий Олимпийн эд хөрөнгө, өмчийн бүх эрхийг бүрэн эрхтэйгээр эзэмшинэ. Тиймээс Олимпийн хөдөлгөөн түүний бүрэлдхүүн хэсгүүдийн эрх ашгийн үүднээс ашиг орлого олох бүхий л Олимпийн эд хөрөнгө, өмчийн эрхийг ОУОХ нь чандлан хамгаалж мөн эдгээрийг ашиглах зөвшөөрлийг өгнө.
2. Олимпийн наадам нь ОУОХ –ны онцгой өмч бөгөөд ОУОХ нь одоо ашиглагдаж байгаа болон ирээдүйд ашиглагдах бүх төрлийн хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр Олимпийн наадмын талаар хэвлэх, дамжуулах, нэвтрүүлэх, бичлэг хийх, тоо баримт ашиглах, зохион байгуулах бүхий л эрхийг хугацаагүй эрхтэйгээр эзэмшинэ.
3. ОУОХ нь Олимпийн наадам түүний төрлүүдийн тэмцээний тоо баримт, дүнгийн талаархи мэдээлэлд нэвтрэн орох, ашиглах нөхцөлийг тогтооно.
4. Дүрмийн 8-14-т доорхи байдлаар тодорхойлогдсоны дагуу Олимпийн бэлэгдэл, далбаа, уриа, дуулал, таних тэмдэг / зөвхөн Олимпийн тоглолтонд хамааралтай бус /, тэмдэглэгээ, эмблемүүд, гал, бамбаруудыг нэгж, хэсгээр болон бүхлээрээ “Олимпийн эд хөрөнгө, өмч” гэж үзнэ. Олимпийн эд хөрөнгө, өмчийг эзэмших болон ашиглах бүх эрх онцгой эрхтэйгээр зөвхөн ОУОХ-нд байна. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь ОУОХ нь эд хөрөнгө, өмчийг бүхлээр нь болон хэсэгчлэн ашиглах эрх түүний нөхцөлийг батлан гаргана.

8 Олимпийн бэлэгдэл*

Олимпийн бэлэгдэлийг дангаар нь хэрэглэдэг бөгөөд энэ нь адил хэмжээтэй хоорондоо хэлхээтэй холбогдсон өөр өөр өнгө бүхий таван цагирагаас / Олимпийн цагираг / бүрдэнэ. Эдгээр таван өөр өнгө бүхий цагираг нь зүүнээс баруун тийш цэнхэн, шар, хар, ногоон, улаан гэсэн дараалалтай байна. Эдгээр хоорондоо холбогдсон цагираг нь дээд талдаа зүүнээс баруун тийш цэнхэр, хар, улаан харин доод талдаа шар, ногоон цагирагууд нь дараахь дүрслэлтэйгээр байрлана. Олимпийн бэлэгдэл нь Олимпийн тоглолтонд дэлхийн таван тивээс цугларсан тамирчдын эв нэгдлийг харуулж, Олимпийн хөдөлгөөний үйл ажиллагааг илэрхийлнэ.

9 Олимпийн далбаа*

Олимпийн далбаа нь ямарч хүрээгүй цагаан суурьтай байна. Таван өнгө бүхий Олимпийн билэг тэмдэг нь энэхүү далбааны голд байрлана.

10 Олимпийн уриа*

Олимпийн уриа “Citius Altius Fortius” / хурднаас хурдан, өндрөөс өндөрт, хүчтэйгээс хүчтэй/ нь Олимпийн Хөдөлгөөний хүсэл, эрмэлзлэлийг илэрхийлнэ.

11 Олимпийн эмблемүүд*

Олимпийн эмблем нь Олимпийн цагираг болон бусад тодорхой элементтэй хосолсон загвар, зохиомж байна.

12 Олимпийн дуулал*

Олимпийн дуулал нь Спиро Самарагийн зохиосон “Олимпийн дуулал” нэртэй хөгжмийн бүтээл болно.

13 Олимпийн гал, Олимпийн бамбарууд*

1. Олимпийн гал нь ОУОХ-ны ивээл доор Олимпийн наадамын өлгий нутаг Олимпиа хотод асаасан гал юм.
2. Олимпийн бамбар нь ОУОХ-ноос хүлээн зөвшөөрөгдсөн Олимпийн галыг асаах зорилго бүхий ижил загвартай авч явах зориулалтай бамбар болно.

14 Олимпийн холбогдолтой дүрс бичлэг

Олимпийн дүрс бичлэг гэдэг нь Олимпийн наадам, Олимпийн хөдөлгөөн түүний бүрэлдхүүн хэсгүүдийн бүх төрлийн дүрс болон дуу бичлэгийн хэлбэрийг хэлнэ.

Дүрмийн 7-14-д хамаарах заалтууд:

1. Хууль эрх зүйн хамгаалалт:
 - 1.1 ОУОХ нь Олимпийн наадам болон Олимпийн эд хөрөнгө, өмчийн эрхийг эзэмших, хууль эрх зүйн үүднээс хамгаалах бүхий л боломжит алхамуудыг үндэсний болон олон улсын түвшинд авч хэрэгжүүлж болно.
 - 1.2 Дүрмийн 7-14-д хамаарах заалтуудуудын дагуу ҮОХ бүр өөрийн улсдаа ОУОХ-нд мэдээлэл хийж хариуцлагатай ажиллана. Олимпийн харти түүнд хамаарах заалтуудыг зөрчиж Олимпийн эд хөрөнгө, өмчийг хэрэглэж буй аливаа үйлдлийг зогсоох алхам хийнэ. Энэ нь ОУОХ, Олимпийн эд хөрөнгө, өмчийг хамгаалах, ОУОХ-г дэмжиж байгаа хүчин чармайлт мөн.
 - 1.3 Тухайн улсын барааны тэмдэгийг баталгаалжуулах газар, хуулийн бусад хэрэгсэлүүд нь хууль эрх зүйн хамгаалалт олгож байгаа тохиолдолд тухайн ҮОХ нь ОУОХ-ны заавар удирдамж, Олимпийн хартын дагуу

Олимпийн бэлэгдэл болон Олимпийн бусад эд хөрөнгө, өмчийг хэрэглэж болно.

1.4 YOX нь Олимпийн эд хөрөнгө, өмч түүнийг хуулийн хүрээнд хамгаалахтай холбоотой гуравдагч этгээдтэй үүссэн гарсан аливаа маргааныг шийдвэрлэхэд ОУОХ-той холбогдож туслалцаа авч болно.

1.5 ОУОХ нь Олимпийн эд хөрөнгө, өмч түүнийг хуулийн хүрээнд хамгаалахтай холбоотой гуравдагч этгээдтэй үүссэн гарсан аливаа асуудлыг шийдвэрлэхэд YOX-той холбогдож туслалцаа авч болно.

2. ОУОХ гуравдагч этгээдэд Олимпийн эд хөрөнгө, эрхийг хэрэглэх ашиглах тусгай зөвшөөрөл, лиценз олгох

2.1 ОУОХ нь нэг болон хэд хэдэн Олимпийн эмблемийг зохиож түүнийгээ ашиглаж болно.

2.2 Олимпийн бэлэгдэл, Олимпийн эмблем болон Олимпийн эд хөрөнгө, өмчийг зэргийг ОУОХ болон хэрэглэх зөвшөөрөл авсан хувь хүн, YOX-д ашиглах бөгөөд дараахь нөхцөлийг биелүүлнэ:

2.2.1 2.2.2 хэсэгт зааснаас бусад тохиолдолд Олимпийн эд хөрөнгө, өмчийг хэрэглэхээр ивээн тэтгэгчид, нийлүүлэгчидтэй хийсэн гэрээ болон бусад бүх маркетингийн үйл ажиллагаа нь тухайн YOX-ны ашиг сонирхолтой зөрчилдөхгүй бол ОУОХ нь YOX-той зөвшөлцөж эд хөрөнгө, өмчийг хэрэглэсний цэвэр ашгийн талыг авах эсэхийг шийднэ.

2.2.2 YOX нь лиценз, зөвшөөрөл олгох гэрээнээс олсон ашгаас татвар болон бусад гэрээтэй холбоотой гарсан зардлыг хасаж цэвэр ашгийн талыг авна. Ийм гэрээг YOX-д урьдчилан мэдэгдэнэ.

2.2.3 ОУОХ нь Олимпийн наадмыг нэвтрүүлэгч дамжуулагчид болон Олимпийн наадмыг зохион байгуулах хороонд Олимпийн бэлэгдэл, ОУОХ-ны эмблемүүд, Олимпийн эд хөрөнгө, өмчийг ашиглах зөвшөөрлийг өөрийн үзэмжээр дангаар шийдвэрлэн олгож болно. Энэхүү зөвшөөрөлд дүрмийн 2.2.1 болон 2.2.2 заалтууд нь хамаарахгүй.

3. Олимпийн бэлэгдэл, далбаа, уриа болон дуулалыг ашиглах:

3.1 Энэхүү дүрмийн 2.2 бүлэгт зааснаар Олимпийн бэлэгдэл, далбаа, уриа болон дуулалыг ОУОХ нь өөрийн үзэмжээр ашиглаж болно.

3.2 ҮОХ-д нь Олимпийн хөдөлгөөний хөгжил дэвшилд тус нэмэр болж, түүний нэр хүндэнд сөрөг нөлөө үзүүлэхээргүй бол ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс урьдчилан авсан зөвшөөрөлтөйгөөр Олимпийн бэлэгдэл, далбаа, уриа болон дуулалыг ашгийн бус зорилгоор ашиглаж болно.

4. ҮОХ болон ОНЗБХ нь Олимпийн эмблемийг зохион бүтээж ашиглах нь:

4.1 ОУОХ-ноос зөвшөөрсөний дагуу ҮОХ болон ОНЗБХ нь Олимпийн эмблемийг зохион бүтээж болно.

4.2 ОУОХ нь тухайн Олимпийн эмблемийг хэв загвар, зохиомжын хувьд бусад Олимпийн эмблемээс ялгаатай байгаа эсэхийг шалгаж батална.

4.3 Олимпийн бэлэгдэл нь тухайн Олимпийн эмблемийн байрших талбайн гуравны нэгээс их биш талбайг эзэлнэ. Олимпийн бэлэгдэл нь Олимпийн эмблемэнд ямар нэгэн өөрчлөлтгүй бүтнээрээ байх ёстой.

4.4 Түүнчлэн ҮОХ-ны Олимпийн эмблем нь дараахь нөхцлийг хангана:

4.4.1 Эмблем нь тухайн улсын ҮОХ-ны онцлогыг тодорхой агуулсан хэв загвартай байна.

4.4.2 Эмблемийн ялгарах онцлог хэсэг нь тухайн ҮОХ-ны зөвхөн нэр болон түүний товчлол гэх мэт элемент байж болохгүй.

4.4.3 Эмблемийн ялгарах онцлог хэсэгт тодорхой Олимпийн наадам, он сар өдөр зэрэг хугацаатай хамааралтай элемент байж болохгүй.

4.4.4 Эмблемийн ялгарах онцлог хэсэгт мөн Олон улсын чанартай хэрэглэгдэж болох уриа лоозон, тэмдэглэгээ, хэллэг зэрэг элемент байж болохгүй.

4.5 Дээрхи 4.1; 4.2 болон 4.3 заалтуудаас гадна ОНЗБХ-ны Олимпийн эмблем нь дараахь дараахь нөхцлийг хангана:

4.5.1 Эмблем нь Олимпийн наадам, ОНЗБХ-ны онцлог шинж зэргийг маш тодорхой гаргаж өгсөн хэв загвар, зохиомжтой байна.

- 4.5.2 Эмблемийн ялгарах онцлог хэсэг нь тухайн ОНЗБХ-ны зөвхөн нэр болон түүний товчлол гэх мэт элемент байж болохгүй.
- 4.5.3 Эмблемийн ялгарах онцлог хэсэгт мөн Олон улсын чанартай хэрэглэгдэж болох уриа лоозон, тэмдэглэгээ, хэллэг зэрэг элемент байж болохгүй.
- 4.6 Дээрхи заалтууд хүчин төгөлдөр болохоос өмнө ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс баталсан аль ч Олимпийн эмблемүүд хүчинтэй хэвээр байна.
- 4.7 Тухайн улсын ҮОХ нь аливаа тохиолдолд боломжтой бол ҮОХ-ныхоо Олимпийн эмблемийг бүртгүүлж хуулиар хамгаалалуулах арга хэмжээ авна. ҮОХ нь Олимпийн эмблемээ ОУОХ-гоор баталгаажуулснаас хойш зургаан сарын дотор бүртгүүлж бүртгүүлсэн баталгаагааны хуулбарыг ОУОХ-нд явуулна. Хэрэв ҮОХ нь Олимпийн эмблемээ бүртгүүлж хуулиар хамгаалуулах арга хэмжээ авахгүй бол ОУОХ нь тухайн баталсан Олимпийн эмблемийг цуцлаж болно. Үүний нэгэн адил ОНЗБХ нь ОУОХ-ны заавар удирдамжын дагуу Олимпийн эмблемээ хуулиар хамгаалуулах арга хэмжээ авна. ҮОХ болон ОНЗБХ-ны хийсэн Олимпийн эмблемийн хамгаалалтууд нь ОУОХ-ны эсрэг уриалсан байж болохгүй.
- 4.8 Олимпийн эмблемийг зар сурталчилгаа, арилжаа, ашиг олох зэрэг зорилгоор хэрэглэж байгаа тохиолдолд энэхүү дүрмийн доорхи 4.9 болон 4.10 заалтуудын дагуу гүйцэтгэнэ.
- 4.9 Бүх ҮОХ-д ОНЗБХ нь Олимпийн эмблемийг шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан зар сурталчилгаа, арилжаа, ашиг олох зэрэг зорилгоор хэрэглэж байгаа тохиолдолд энэхүү бүлгийн заалтуудыг мөрдлөг болгон гуравдагч этгээдэд хяналт тавин ажиллана.
- 4.10 ОНЗБХ-ны хийсэн болон бусад бүх гэрээ, тохиролцоонууд нь ҮОХ-гоор баталгаажиж дараахь зарчмыг мөрдлөг болгоно:
- 4.10.1 Тухайн ҮОХ-ны Олимпийн эмблем нь зөвхөн тухайн улс дотор хүчин төгөлдөр хэрэглэгдэнэ. Тухайн ҮОХ-ны Олимпизмтэй хамаарал бүхий эмблем, билэг тэмдэг, тэмдэг, тэмдэглэгээ зэргийг

өөр улсын ҮОХ нь урьдчилан бичгээр авсан зөвшөөрөлгүй бол зар сурталчилгаа, арилжаа, ашиг олох зэрэг зорилгоор хэрэглэж болохгүй.

4.10.2 Дээрхийн нэгэн адил тухайн ОНЗБХ -ны Олимпизмтэй хамаарал бүхий эмблем, билэг тэмдэг, тэмдэг, тэмдэглэгээ зэргийг тухайн ҮОХ-ноос урьдчилан бичгээр авсан зөвшөөрөлгүй бол зар сурталчилгаа, арилжаа, ашиг олох зэрэг зорилгоор хэрэглэж болохгүй.

4.10.3 Бүх тохиолдолд ОНЗБХ-той хийсэн гэрээний хүчинтэй хугацаа нь тухайн Олимпийн тоглолттой жилийн 12-р сарын 31-ныг хүртэл байна.

4.10.4 Олимпийн эмблем нь Олимпийн хөдөлгөөний нэр хүндэд сөргөөр нөлөөлөх байдлаар биш харин хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх зорилгоор хэрэглэгдэнэ. ОУОХ-ноос гаргасан Олимпийн Харт, Олимпизмийн үндсэн зарчмуудтай нийцэхгүй бол Олимпийн эмблемүүд, бүтээгдхүүн үйлчилгээг хэрэглэхийг хориглоно.

4.10.5 ОУОХ-ны хүсэлтийн дагуу бүх ҮОХ-д болон ОНЗБХ нь байгуулсан гэрээний хуулбарыг өгнө.

5. Шуудангийн марк

ОУОХ-ноос тавьсан нөхцөлийн дагуу ОУОХ нь тухайн улсын ҮОХ-г Олимпийн бэлэгдэлийг ашиглан ОУОХ-той хамтарсан марк гаргахад дэмжин хамтран ажиллаж болно.

6. Хөгжмийн бүтээл

ОНЗБХ болон зохион байгуулах хот, тухайн улсын ҮОХ нь ОУОХ-ны журам зааврын дагуу ялангуяа Олимпийн Наадамтай холбоотой сэтгэлд нийцэхүйц хөгжмийн зохиол, аясыг хийсэн тохиолдолд түүний зохиогчын эрхийг ОУОХ-ны мэдэлд шилжүүлэх журмыг ОУОХ-ны шаардлаганд нийцүүлэн биелүүлэх арга хэмжээ авна.

ОЛОН УЛСЫН ОЛИМПИЙН ХОРОО /ОУОХ/

15 Хууль эрх зүйн хэм хэмжээ

1. ОУОХ нь Швецарийн Холбооны Улсын Зөвлөлийн 2000 оны 11-р сарын 01 ны өдрийн гэрээний дагуу хүлээн зөвшөөргөдсөн төрийн бус, ашгийн төлөө бус , хувь хүний адил хууль эрх зүйн статустай, тодорхой хугацаагүйгээр байгуулагдсан Олон улсын байгууллага мөн.
2. Олимпийн нийслэл нь Швецарь улсын Люзань хотод байрлана.
3. ОУОХ-ны зорилго нь Олимпийн Хартид тодорхойлсон түүний эрхэм зорилго, зорилтууд, үүргүүдийн биелүүлэхэд оршино.
4. ОУОХ нь өмнөө тавьсан эрхэм зорилго, үүргүүдээ амжилттай биелүүлэхийн тулд хуулийн хүрээнд сан, хоршоог байгуулан эзэмшиж эсвэл өөрийн эрх мэдлийн дор ажлуулж болно.

16 Гишүүд*

1. ОУОХ-ны бүрэлдхүүнд – шинэ гишүүн элсүүлэх, сонгох, батлах, эрх хэмжээг нь тодорхойлох
 - 1.1 ОУОХ-ны гишүүд нь хувь хүмүүс байна. Дүрмийн 16-д заасны дагуу ОУОХ-ны гишүүд нь 115-с хэтрэхгүй байна. ОУОХ нь дараахь гишүүдээс бүрэлдэнэ:
 - 1.1.1 дүрмийн 16-ийн 2.2.5 заалтаар тодорхойлосны дагуу ихэнхи гишүүд буюу 70 хүртэлхи гишүүд нь ямар нэгэн чиг үүрэг, албанд хамаарагдаагүй сонгогдсон хүмүүсээ бүрдэнэ. Ийм статустай гишүүн Дүрмийн 16-д тодорхойлосноор тухайн улсаас зөвхөн нэгээс хэтрэхгүй тоотой байна.
 - 1.1.2 Идэвхитэй бэлтгэл сургуулилалт хийж байгаа тамирчидийн тоо нь дүрмийн 16-ийн 2.2.2 заалтын дагуу 15-аас хэтрэхгүй байна.
 - 1.1.3 ОУСХ-д болон ОУСХ-дийн нэгдсэн холбоо, ОУОХ-гоор хүлээн зөвшөөргөдсөн бусад байгууллагуудын ерөнхийлөгчид болон тэдгээрт өндөр албан тушаал эрхэлдэг хүмүүсийн тоо нь 15-с хэтрэхгүй байна.

- 1.1.4 ҮОХ-д болон тивийн ҮОХ-дийн зөвлөлд ерөнхийлөгч болон тэдгээрт өндөр албан тушаал эрхэлдэг хүмүүсийн тоо нь 15-с хэтрэхгүй байна. Энэ тоонд нэг улсаас нэгээс илүүгүй тоотой гишүүн байна.
- 1.2 ОУОХ нь дүрмийн 16-д заасны дагуу ОУОХ-ны шалгуурыг хангасан гэж үзсэн хүмүүсээс гишүүнээр сонгодог.
- 1.3 ОУОХ нь шинэ гишүүдийг албан үүргээ дагаж мөрдөх талаар доорхи тангараг өргүүлж албан, баяр ёслолын байдалтайгаар элсүүлдэг:
“ Миний бие ОУОХ-д хүндэтгэлтэйгээр гишүүнээр элсэж байгаан учир тангараглах нь: Би өөрийн үүрэг хариуцлагаа ухамсарлан, Олимпийн хөдөлгөөнийг түгээн дэлгэрүүлэхэд бүх боломж чадвараа дайчлан, ОУОХ-ны шийдвэр болон Олимпийн харти түүний заалтуудыг ямар ч эсэргүүцэлгүй хүндэтгэн сахиж, ёс зүйн хэв журам дүрмийг даган, улс төрийн болон арилжааны бүх нөлөөлөлөөс ангид байж, шашны болон арсьны үзэл түүнчилэн бүхий л ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг тэмцэж, ОУОХ болон Олимпийн хөдөлгөөний ашиг сонирхолд нийцүүлэн түүнийг дэмжин ажиллахаа тангараглаж байна.”
- 1.4 ОУОХ-ны гишүүд нь өөрийн улсдаа болон ажиллаж байгаа байгууллагадаа ОУОХ болон Олимпийн хөдөлгөөн түүний ашиг сонирхолыг төлөөлөн ажиллана.
- 1.5 ОУОХ-ны гишүүн нь өөрийн чөлөөт санал, үйл ажиллагаандаа засгийн газар болон бусад байгууллагын шийдвэр, нөлөөлөлийг хүлээн авч болохгүй.
- 1.6 ОУОХ-ны гишүүд нь хувь хүнийхээ тухайд ОУОХ-нд ямар нэгэн өр төлбөрийн хариуцлага үүрэхгүй.
- 1.7 Дүрмийн 16.3 заалтын дагуу ОУОХ-ны гишүүд нь найман жилээр сонгогдог бөгөөд дахин нэг болон хэдэн удаа ч улиран сонгогдож болно. Дахин сонгогдох журмыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл гаргана.

2. Гишүүний үүрэг:

ОУОХ-ны гишүүн бүр дараахь үүрэгтэй:

- 2.1 Олимпийн харт, Ёс зүйн дүрэм болон бусад ОУОХ-ны дүрмүүдийг даган мөрдөх
- 2.2 ОУОХ-ны Чуулгануудад оролцох
- 2.3 Томлигдон орсон ОУОХ-ны хороодын ажилд оролцох
- 2.4 Олимпийн хөдөлгөөн түүнийг түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэхэд нэмэр тус болох
- 2.5 Өөрийн улсын Олимпийн хөдөлгөөний байгууллага болон өөрийн улсад хэрэгжүүлж буй ОУОХ-ны хөтөлбөрүүдийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
- 2.6 ОУОХ-ны ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу өөрийн оронд үйл ажиллагаа явуулж буй Олимпийн хөдөлгөөний байгууллага болон Олимпийн хөдөлгөөний явц, нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагын талаар мэдээлэл хийх
- 2.7 Өөрийн орны Олимпийн хөдөлгөөн, Олимпийн хөдөлгөөний байгуулагуудын үйл явцад Олимпийн Хартыг зөрчин саад болж буй аливаа арга хэмжээг цаг алдалгүй Ерөнхийлөгчид мэдээлэх
- 2.8 Ерөнхийлөгчөөс өгсөн бусад үүрэг даалгаврыг биелүүлэх

3. Гишүүнчлэлийг зогсоох:

Дараахь нөхцөл байдлаар ОУОХ-ны гишүүний гишүүнчлэлийг зогсооно:

3.1 Гишүүнээс татгалзах:

ОУОХ-ны гишүүн нь хүссэн үедээ Ерөнхийлөгчид бичгээр гишүүнээс татгалзах өргөдлөө өгч гишүүнчлэлээ зогсоож болно. Татгалзах өргөдлийг шийдвэрлэхээс өмнө ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл гишүүнээс татгалазах болсон нөхцлийн талаар асууж болно.

3.2 Дахин сонгогдохгүй бол:

Дүрмийн 16.1.7; 16.2.6 болон магадгүй дүрмийн 16.2.7.1 заалтуудын дагуу гишүүн нь дахин сонгогдоогүй бол цааш ямар нэгэн болзолгүй гишүүнчлэл нь зогсоно.

3.3 Насны хязгаар:

Дүрмийн 16.2.7.1 заалтын дагуу ОУОХ-ны гишүүн нь 70-н нас хүрсэн тухайн жилийн эцэст болоход гишүүчлэл нь зогсоно.

3.4 ОУОХ үйл ажиллагаа болон Чуулгануудад идэвхитэй оролцохгүй бол: ОУОХ-ны гишүүн нь 2 жил дараалан ОУОХ үйл ажиллагаа болон Чуулгануудад идэвхитэй оролцохгүй бол гишүүнээс ямар нэгэн тайлбар сонсохгүй гишүүнчлэлийг шууд зогсоно. Энэ тохиолдолд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргасан санлын дагуу Чуулганаар гишүүнчлэлийг зогсоох асуудлыг шийдвэрлэнэ.

3.5 Байнга оршин суух хаяг өөрчлөгдөх, өөр газар сонирхох

ОУОХ-ны гишүүн нь гишүүнээр сонгогдох үедээ амьдарч байсан улс, байнга оршин суух хаяг нь өөрчлөгдөн өөр улсад амьдрах сонирхолтой болсон тохиолдолд дүрмийн 16.1.1.1 тодорхойлсноор гишүүнчлэлийг зогсоно. Энэ тохиолдолд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргасан санлын дагуу Чуулганаар гишүүнчлэлийг зогсоох асуудлыг шийдвэрлэнэ.

3.6 Идэвхитэй бэлтгэл сургуулилалт хийж байгаа тамирчдаас сонгогдсон гишүүн:

Дүрмийн 16.1.1.2-д тодорхойлсоноор идэвхитэй бэлтгэл сургуулилалт хийж байгаа тамирчдаас сонгогдсон гишүүний гишүүнчлэлийг зогсоох асуудлыг ОУОХ-ны тамирчдын хорооноос шийдвэрлэнэ.

3.7 ҮОХ-д, тивийн ҮОХ-дийн зөвлөл, ОУСХ-д болон ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагуудын ерөнхийлөгчид болон тэдгээрт өндөр албан тушаал эрхэлдэг хүмүүсээс сонгогдсон гишүүн:

Дүрмийн 16.1.1.2-д тодорхойлсоноор сонгууль болох үед хашиж байсан албан тушаалаа больсон тохиолдолд ОУОХ-ны гишүүнчлэлийг даруй зогсоно.

3.8 Гишүүнээс хөөх:

3.8.1 Хэрэв Чуулганаар ОУОХ-ын гишүүнийг өргөсөн тангарагаа биелүүлэхгүй, ОУОХ-ны ашиг сонирхолыг үл тоон түүний эсрэг санаатай үйлдэл хийсэн, ОУОХ-ны нэр хүндийг унагасан гэж үсвэл Чуулганы шийдвэрээр гишүүнээс хөөнө.

- 3.8.2 ОУОХ-ны гишүүнээс хөөх санлыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргаж Чуулганаар шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэр нь Чуулганы төлөөлөгчдийн гуравны хоёроос дээш саналаар шийдэгдэнэ. Гишүүн нь энэхүү шийдвэртэй танилцах, биечлэн сонсох мөн өөрийгөө хамгаалсан захидал бичиж болно.
- 3.8.3 Чуулганы шийдвэр гартал ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс тухайн гишүүний онцгой эрх бусад эрхүүд, ажил үүргийг урьдчилан заримыг нь болон бүгдийг түдгэлзүүлэж болно.
- 3.8.4 ОУОХ-ноос хөөгдсөн гишүүн нь ҮОХ, ҮОХ-ны холбоод, ОНЗБХ-ны гишүүн байж болохгүй.

4. Хүндэт Ерөнхийлөгч – Хүндэт гишүүн – Өргөмжит гишүүн

- 4.1 ОУОХ-ны санлын дагуу Чуулганаар ОУОХ-ны Ерөнхийлөгчөөр онцгой гавъяатай ажилласан ОУОХ-ны гишүүнийг ОУОХ-ны Хүндэт Ерөнхийлөгчөөр сонгож болно. Хүндэт Ерөнхийлөгч нь өөрийн зөвөлгөө, зөвлөмж өгөх эрхтэй.
- 4.2 ОУОХ-ны гишүүнээр араваас доошгүй жил онцгой гавъяатай ажиллаж тэтгэвэрт гарч байгаа ОУОХ-ны гишүүнийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн санлын дагуу Чуулганаар ОУОХ-ны Хүндэт гишүүнээр сонгож болно.
- 4.3 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн санлын дагуу ОУОХ-ны гишүүн бус атлаа Олимпизмийн төлөө онцгой гавъяа байгуулан ажиллаж байгаа хувь хүнийг Чуулганаар ОУОХ-ны Өргөмжит гишүүнээр сонгож болно.
- 4.4 Хүндэт Ерөнхийлөгч, Хүндэт гишүүн, Өргөмжит гишүүн нь насан турш сонгогдоно. Тэдгээр нь ОУОХ-нд албан өрөө байхгүй, сонгууль өгөх эрхгүй. Тэдэнд дүрмийн 16.1.1 – 1.5, 16.1.7, 16.2, 16.3 болон 16.1, 16.2 заалтууд хамаарахгүй. Тэднийг эрх хэмжээг Чуулганы шийдвэрээр эргүүлэн татаж болно.

Дүрмийн 16-д хамаарах заалтууд:

1. Сонгуульд оролцох нөхцөл:

Дараахь нөхцлийг хангасан тохиолдолд 18 болон түүнээс дээш насны хүмүүс ОУОХ-ний гишүүн байж болно:

1.1 Доорхи 2.1 заалтын дагуу нэр дэвшигч нь бүх материалаа өргөн барьсан байна.

1.2 Доорхи 2.2 заалтанд байгаа нөхцөлүүдийг нэр дэвшигч нь биелүүлсэн байна.

1.3 Нэр дэвшигч нь нэр дэвшүүлэх хороогоор шалгагдаж, танилцуулагдана.

1.4 Нэр дэвшигчийн талаар сонгууль хийх санлыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс Чуулганд оруулна.

2. ОУОХ-ны гишүүнээр сонгох журам:

2.1 ОУОХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчийг дэвшүүлэх:

Дараахь хувь хүн, байгууллагууд нь ОУОХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчийг дэвшүүлж болно: ОУОХ-ны гишүүд, ОУСХ-д, ОУСХ-дийн зөвлөл, ҮОХ-д, тивийн болон дэлхийн ҮОХ-дийн зөвлөл болон ОУОХ-гоор хүлээн зөвшөөргдсөн бусад байгууллагууд.

2.2 Нэр дэвшигчдийг хүлээн зөвшөөрөх:

Нэр дэвшигч нь хүлээн зөвшөөрөгдөхийн тулд Ерөнхийлөгчид материалаа бичгээр өргөн барихын зэрэгцээ дараахь нөхцлийг ханган биелүүлсэн байна:

2.2.1 Хувь хүн болон байгууллага нь ОУОХ-ны гишүүний сонгуульд нэр дэвшигчийн нэрийг дэвшүүлэхдээ дүрмийн доорхи 2.2.2 заалтын дагуу тухайн нэр дэвшигч нь спортоор идэвхитэй хичээллэж байгаа тамирчин, эсвэл нэр дэвшигч дүрмийн доорхи 2.2.3 эсвэл 2.2.4 заалтанд хамаарах ямар нэгэн байгууллагад албан тушаал эрхэлдэг эсвэл нэр дэвшигч дүрмийн 2.2.5 заалтын дагуу бие даан нэр дэвшиж байгаа эсэхийг маш тодорхой бичсэн байна.

2.2.2 Хэрэв нэр дэвшигч нь дүрмийн 16.1.1.2-т хамааран спортоор идэвхитэй хичээллэж байгаа тамирчин бол түүний хамгийн

сүүлд оролцсон зуны эсвэл өвлийн Олимпийн наадмаас дараагийн болох Олимпийн наадмын хоорондохи хугацаанд ОУОХ-ны тамирчдын хороонд нэр дэвшигдсэн эсвэл гишүүнээр сонгогдсон байх ёстой.

2.2.3 Хэрэв нэр дэвшигчид нь дүрмийн 3.5-ийн дагуу ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагууд, ОУСХ-д болон ОУСХ-дийн зөвлөлд ерөнхийлөгч болон удирдах, хариуцлагатай албан тушаал эрхэлдэг хувь хүмүүс бол.

2.2.4 Хэрэв нэр дэвшигч нь ҮОХ-д болон тив, дэлхийн ҮОХ-дийн зөвлөлд ерөнхийлөгч болон удирдах, хариуцлагатай албан тушаал эрхэлдэг хувь хүмүүс бол.

2.2.5 Бие даан нэр дэвшигч хувь хүн нь ямар нэгэн улсын байнгын оршин суух зөвшөөрөлтэй, иргэншилтэй тухайн улсад нь ҮОХ үйл ажиллагаа явуулдаг бол.

2.3 ОУОХ-ны нэр дэвшүүлэх хороо:

2.3.1 ОУОХ-ны нэр дэвшүүлэх хороо нь дүрмийн 16.2.4 болон 21.3-д хамаарах заалтуудын дагуу ОУОХ-нд гишүүнээр нэр дэвшигчдийг шалган нягтладаг.

2.3.2 ОУОХ-ны нэр дэвшүүлэх хороонд ОУОХ-ны ёс зүн хороо, ОУОХ-ны тамирчдын хорооноос доод тал нь тус бүр нэг нэг төлөөлөлийг оруулна.

2.4 ОУОХ-ны нэр дэвшүүлэх хорооны үүрэг:

2.4.1 ОУОХ-ны нэр дэвшүүлэх хороо нь бүх ОУОХ-ны гишүүнчлэлийн сонгуульд нэр дэвшигчдийг шалган нягтлах үүрэгтэй. Бүх нэр дэвшигчид нь ОУОХ-ны Ерөнхийлөгчийн тогтоосон хугацаанд материалаа ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд бичгээр ирүүлсэн байна.

2.4.2 ОУОХ-ны нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигчийн ажил мэргэжил, эд хөрөнгө, спортын амжилт замнал гэх мэт олон талтай мэдээлэлийг цуглуулна. Мөн нэр дэвшигчийн талаар мэдээлэл өгөх боломжтой байгууллагаас тодорхойлолт авч,

шаардлагатай бол нэр дэвшигчийг ярилцлаганд урьж оролцуулж болно.

2.4.3 ОУОХ-ны нэр дэвшүүлэх хороо нь нэр дэвшигч бүрийн сонгуульд нэрээ дэвшүүлэх боломж, нөхцөл, зөвшөөрөгдөх эсэхийг мөн түүнчлэн шаардалгатай бол спортоор идэвхитэй хичээллэж байгаа тамирчдын, мөн бусад нэр дэвшигчдийн албан тушаал, ажил үүргийг нягтлан шалган баталгаажуулна.

2.5 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр хэлэлцэх журам

2.5.1 ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл нь дангаараа Чуулганд нэр дэвшигчийг оруулах бүрэн эрхтэй. ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл нь нэр дэвшигдэж буй хүний талаархи саналаа Нэр дэвшүүлэх хорооноос гаргасан тайлангийн хамт Чуулган эхлэхээс нэг сараас доошгүй хугацаанд Чуулганд бичгээр өргөн барина. ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл нь нэр дэвшигчийн талаархи мэдээлэлийг сонсож мөн хэд хэдэн нэр дэвшигчид нь зөвхөн нэг гишүүний эрхийн төлөө өрсөлдөж болно.

2.5.2 Шаардалгатай гэж үзвэл дүрмийн 2.2.1 болон 2.2.2 заалтын дагуу спортоор идэвхитэй хичээллэж байгаа тамирчдаас нэр дэвшиж байгаа нэр дэвшигчдийг хянах, шалгах журамыг хурдасгаж, дүрмийн 2.4.1 болон 2.5.1 заалтанд байгаа хугацааг хэрэгсэхгүй болгож ОУОХ-ны тамирчдын хороонд шинээр сонгогдсон гишүүний ОУОХ-нд гишүүнээр сонгох сонгуулийг яаралтай хийж болно.

2.6 Чуулганаар хэлэлцэх журам:

2.6.1 Чуулган нь дангаараа ОУОХ-ны гишүүнийг сонгох бүрэн эрхтэй.

2.6.2 Нэр дэвшүүлэх хорооны дарга нь хорооноос гаргасан саналаа Чуулганд мэдээлэх, танилцуулах эрхтэй.

2.6.3 ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс ОУОХ-д гишүүнээр элсэх бүх нэр дэвшигчдийг Чуулганд оруулж санал хураалгана. Саналыг нууцаар хурааж, олонхийн саналаар шийдвэр гарна.

2.7 Завсарын заалтууд:

110 дахь удаагийн Чуулганаас /1999 оны 12-р сарын 11/ өмнө сонгогдсон ОУОХ-ны гишүүдийн эрх нь дараахь байдлаар хангагдана:

2.7.1 ОУОХ-ны гишүүн нь 1966 оноос өмнө сонгогдоогүй бол харин 110 дахь удаагийн Чуулганаас /1999 оны 12-р сарын 11/ өмнө сонгогдсон ОУОХ-ны гишүүн нь хуанлийн заалтаар 80-нас хүрээд гишүүнээс тэтгэвэрт гарна. Хэрэв ОУОХ-ны Ерөнхийлөгч, дэд еөрнхийлөгч, ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүний албан тушаал хашиж байхад тэтгэвэрт гарах нас болвол хугацаагаа дуусгаж дараагийн Чуулганы эцсийн өдрөөр тэтгэвэрт гарна.

2.7.2 Дүрмийн 16.1.1.1-р тодорхойлсон нэг гишүүнтэй улсад тухайн гишүүн нь 110 дахь удаагийн Чуулганаас /1999 оны 12-р сарын 11/ өмнө сонгогдсон бол дээрхи 16.1.1.1-р заалтын сүүлчийн өгүүлбэр хамаарахгүй.

3. Гишүүдийг бүртгэх:

ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл нь бүх ОУОХ-ны гишүүд, Хүндэт Ерөнхийлөгч, Хүндэт гишүүн, Өргөмжит гишүүдийн бүртгэлийг хөтөлнө. Бүртгэлд гишүүд бүрийг аль улсын иргэншилтэй, сонгогдохдоо спортоор идэвхитэй хичээллэж байгаа эсвэл, спортын салбарт өндөр албан тушаал хашиж байгаа эсвэл, бие даан сонгогдсон зэрэг бүх мэдээлэлүүдийг тодорхой бүртгэдэг.

4. Хүндэт Ерөнхийлөгч – Хүндэт гишүүн – Өргөмжит гишүүн

4.1 Хүндэт Ерөнхийлөгч нь Олимпийн наадам, Олимпийн конгресс, Чуулган болон ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн хуралд урилгаар оролцож Ерөнхийлөгчийн дэргэд суудаг. Хүндэт Ерөнхийлөгч нь зөвөлгөө өгөх эрхтэй.

4.2 Хүндэт гишүүд нь Олимпийн наадам, Олимпийн конгресс болон Чуулганд урилгаар оролцон тусгайлан захиалсан байранд сууж Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу зөвөлгөө, зөвлөмж өгч болдог.

4.3 Өргөмжит гишүүд нь Олимпийн наадам болон Олимпийн конгресст урилгаар оролцон тусгайлан захиалсан байранд суудаг. Ерөнхийлөгч тэднийг бас ОУОХ-ны уулзалтууд болон бусад арга хэмжээнд урьж оролцуулж болдог.

17 БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ОУОХ нь дараахь нэр бүхий эрх барих байгуулагаас бүрдэнэ:

1. Чуулган
2. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл
3. Ерөнхийлөгч

18 ЧУУЛГАН*

1. ОУОХ-ны нийт гишүүдийн Ерөнхий гол уулзалтыг чуулган гэх бөгөөд энэ нь ОУОХ-ны эрх барих дээд байгууллага мөн. Чуулганаас гарах шийдвэр нь эцсийн шийдвэр байна. Ээлжит чуулганууд нь жилд нэг удаа хуралддаг. Ээлжит бус Чуулганыг бүх гишүүдийн гуравны нэгээс доошгүй гишүүдийн бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Ерөнхийлөгч зарлан хуралдуулна.
2. Чуулган нь дараахь эрх мэдэлтэй:
 - 2.1 Олимпийн Хартад нэмэлт өөрчлөлт оруулах, батлах
 - 2.2 ОУОХ-ны гишүүд, Хүндэт Ерөнхийлөгч, Хүндэт гишүүн, Өргөмжит гишүүдийг сонгох
 - 2.3 Ерөнхийлөгч, дэд-ерөнхийлөгч болон ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдийг сонгох
 - 2.4 Олимпийн наадмыг зохион байгуулах хотыг сонгох
 - 2.5 Ээлжит Чуулган болох хотыг сонгох мөн ээлжит бус чуулган болох хотыг Ерөнхийлөгч нэрлэх
 - 2.6 ОУОХ-ны жилийн тайлан болон төсөвийг сонсон батлах

- 2.7 ОУОХ-ны аудитыг батлах, нэрлэх
- 2.8 ҮОХ-д, ҮОХ-дийн зөвлөл, ОУСХ-д, ОУСХ-дийн Зөвлөл, болон бусад байгууллагуудад бүрэн эрхт болон түр гишүүнчлэлийг олгох, татгалзуулах шийдвэр гаргах
- 2.9 ОУОХ-ны гишүүнээс хөөх, Хүндэт Ерөнхийлөгч, Хүндэт гишүүн, Өргөмжит гишүүдийн эрх хэмжээг эргүүлэн татах
- 2.10 Олимпийн Харт болон хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэх шийдвэр гаргах
3. ОУОХ-ны бүх гишүүдийн тал хувь дээр дахин нэг гишүүн байвал Чуулганы ирцийг хүчинтэйд тооцно. Чуулганы шийдвэрийг саналын ихэнхи дээр үндэслэн гаргана. Гэхдээ Олимпизмийн үндсэн зарчмууд, Олимпийн Хартын дүрмийн заалтуудын зэрэгт өөрчлөлт оруулах бол саналын гуравны хоёр дээр үндэслэн шийдвэр гаргана.
4. Гишүүн бүр нэг саналын эрхтэй. Түдгэлзсэн, хоосон орхисон, эсвэл гэмтсэн саналын хуудасуудыг хүчингүйд тооцно. Саналыг итгэмжлэсэн төлөөлөлөөр өгөхийг хориглоно. Олимпийн Харт дагуу эсвэл хэрэв чуулганд оролцож буй бүх гишүүдийн дөрөвний нэг хувийн хүсэлтээр саналыг нууцаар авах эсэхийг Чуулганы дарга шийдвэрлэнэ. Хэрэв санал тэнцвэл Чуулганы дарга шийдвэр гаргана.
5. Дүрмийн 18.3 болон 18.4 заалтууд нь зохион байгуулах хот болон хувь хүний сонгуульд хамаарна. Хэрэв сонгуульд хэд хэдэн хот эсвэл хоёрхон хот, хувь хүн үлдэж өрсөлдвөл саналын ихэнхийг авсан нэр дэвшигч сонгогдоно.
6. Чуулган нь эрх мэдлээ ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд шилжүүлж болно.

Дүрмийн 18-д хамаарах заалтууд

1. ОУОХ нь бүх Чуулганы санхүүгийн болон бусад бүхийл зохион байгуулах бэлтгэл ажлыг хариуцана.
2. Ээлжит чуулганы товыг чуулган эхлэхээс зургаан сараас доошгүй хугацаанд ОУОХ-ны бүх гишүүдэд мэдэгдэнэ. Ээлжит чуулган түүгээр

хэлэлцэх асуудлын хөтөлбөр нь ээлжит чуулган эхлэхээс гучаас доошгүй хоногийн өмнө, харин ээлжит бус чуулган түүгээр хэлэлцэх асуудлын хөтөлбөр нь ээлжит бус чуулган эхлэхээс араваас доошгүй хоногийн өмнө тус тус Ерөнхийлөгчийн тушаалаар тараагдана.

3. Хүндэтгэх шалтгааны улмаас Ерөнхийлөгч Чуулганд оролцож чадахгүй бол дэд ерөнхийлөгч, хэрэв мөн дээрхийн адил шалтгаанаар дэд ерөнхийлөгч оролцож чадахгүй бол ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн ахлах гишүүн нь Чуулганыг даргална.
4. Олимпийн хартанд нэмэлт өөрчлөлт оруулсан гэх мэт Чуулганаар шийдэгдсэн бүх асуудлууд хэрэв Чуулганаас онцгойлон тогтоогоогүй бол шууд хэрэгжиж эхэлнэ. Хэрэв Чуулганы хэлэлцэх асуудлын хөтөлбөрт ороогүй асуудлыг Чуулганд оролцож буй гишүүдийн гуравны нэг нь хэлэлцэх зүйтэй нь гэж үзвэл эсвэл Чуулганы дарга зөвшөөрвөл хэлэлцэж болно.
5. ОУОХ-ны гишүүнийг дараахь нөхцөл байдалд санал өгөхийг хориглоно:
 - 5.1 Хэрэв Олимпийн наадмыг зохион байгуулах хотыг сонгох сонгуульд санал өгөх гишүүн нь тухайн хотын оршин суугч эсвэл тухайн улсын иргэншилтэй бол
 - 5.2 Хэрэв Чуулган, Олимпийн Конгресс болон бусад уулзалт, арга хэмжээг зохион байгуулах ордон, байгууламжыг сонгох сонгуульд санал өгөх гишүүн нь тухайн хотын оршин суугч эсвэл тухайн улсын иргэншилтэй бол
 - 5.3 Хэрэв ОУОХ-ны гишүүнийг сонгох сонгуульд санал өгөх гишүүн нь тухайн нэр дэвшигчтэй нэг улсын иргэншилтэй бол
 - 5.4 Хэрэв ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүн, орон тооны ажил хийх хүнийг сонгох сонгуульд санал өгөх гишүүн нь тухайн нэр дэвшигчтэй нэг улсын иргэншилтэй бол
 - 5.5 Хэрэв санал хураалт нь ямар нэгэн байдлаар тухайн улстай хамааралтай бол тухайн улсын иргэншилтэй гишүүн санал өгөхгүй

Хэрэв гишүүний санал хураалтанд саналаа өгч болох үгүй эсэх нь эргэлзээтэй бол хурлын дарга шийдвэр гаргана.

6. Ерөнхийлөгч нь сонгуулийн бүх дүрэм журамыг тогтооно. Харин Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн дүрэм журамыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс тогтооно.
7. Гишүүдийн уулзалт цуглаан, саналтай холбоотой асуудлууд гэх мэт Олимпийн Хартанд тусгагдаагүй зарим асуудлыг Ерөнхийлөгч тогтоож батална.
8. Яаралтай тохиолдолд нь ОУОХ-ны Ерөнхийлөгч, ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь ОУОХ-ны гишүүдээс электрон шуудан, факс гэх мэт холбоогоор дамжуулан санал авах тогтоол шийдвэрийн төслөө танилцуулж болно.
9. Чуулган болон бүх цуглаан уулзалтууд түүний үйл явц, хөтөлбөрийг ОУОХ-ны Ерөнхийлөгчийн зөвшөөрөлөөр тогтооно.

19 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл

1. Бүтэц:

ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь Ерөнхийлөгч, дөрвөн дэд-Ерөнхийлөгч болон арван гишүүнээс бүрдэнэ. Удирдах Зөвлөлийн гишүүд нь Чуулганы бүрэлдхүүнээс сонгогдоно. Сонгууль бүрт энэхүү зарчим нь мөрдөгдөж байгаа эсэхийг Чуулганаар хянана.

2. Сонгууль, бүрэн эрхийн хугацаа, хугацааг сунгах, сул орон тоо:

2.1 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүдийг Чуулганаар нууц санал хураалт хийж олонхийн саналаар сонгоно.

2.2 Дэд ерөнхийлөгч болон ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн арван гишүүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүн албан үүрэг, чиглэлээс хамаарахгүй дээд тал нь нэг удаа улиран сонгогдож болох буюу найман жил ажиллаж болно.

2.3 Дүрмийн дээрхи 19.2.2 заалтын дагуу ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүн нь найман жил бүрэн эрхээ хэрэгжүүлж амжилттай ажилласны дараа хоёр жил болоод дахин ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн

гишүүнээр сонгогдож болно. Энэ заалт нь Ерөнхийлөгчийн сонгуульд хамаарахгүй.

2.4 Ерөнхийлөгчөөс бусад албан тушаалд орон тоо гарвал дараагийн Чуулганаар тухайн орон тоон дээр сонгууль хийж дөрвөн жилийн хугацаатай сонгоно.

2.5 Чуулганаар шинээр сонгогдсон болон дахин сонгогдсон бүх ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа тухайн Чуулганы сүүлчийн өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Гишүүдийн бүрэн эрхийн хугацаа тухайн жилийн Чуулганы сүүлчийн өдрөөр дуусгавар болно.

2.6 Энэхүү заалтанд жилийн гэдэгийг хоёр Ээлжит Чуулганы хоорондох хугацаагаар ойлгоно.

3. Эрх мэдэл, үүрэг хариуцлагууд:

ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь ОУОХ-ны үйл ажиллагааг удирдан, зохион байгуулж явуулна. Ялангуяа дараахь үүрэг чиглэлийн дагуу ажиллана:

3.1 Олимпийн Хартын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллах.

3.2 ОУОХ-ны дотоод бүтэц, зохион байгуулал түүний дүрэм журамыг батлах.

3.3 Чуулганд өргөн барьж танилцуулах жилийн санхүүгийн болон аудитын тайлан гэх мэт жилийн тайлангуудыг бэлтгэх.

3.4 Олимпийн харт түүнд хамаарах дүрэм, заалтуудад өөрчлөлт оруулах саналуудыг Чуулганд өргөн барих

3.5 ОУОХ-ны гишүүний сонгуульд нэр дэвших боломжтой нэр дэвшигчдийн нэрсийг Чуулганд танилцуулах

3.6 Олимпийн тоглотын зохион байгуулах хотод нэр дэвших хотын материалыг хүлээн авах болон сонгох үйл явцад хяналт тавих

3.7 Чуулганы хөтөлбөрийг тогтоох батлах

3.8 Ерөнхийлөгчийн зөвлөмжийн дагуу Ерөнхий захиралыг томилох, чөлөөлөх. Ерөнхийлөгч нь түүнд урамшуулал болон шийтгэл, арга хэмжээ авах эсэхийг шийднэ.

- 3.9 Бүх Чуулганууд, ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл болон хороод, ажлын хэсгийн хурлуудын материалууд, ОУОХ-ны санхүүгийн бүх тайлан, мэдээлэлийг хуулийн дагуу хадгалж хамгаалах
- 3.10 Олимпийн Хартыг хэрэгжүүлэх, Олимпийн тоглолтыг амжилттай зохион байгуулах, ОУОХ-ны бүх шийдвэр, дүрэм журмыг сахин биелүүлэхэд шаардагдах боломжит бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх
- 3.11 ОУХ-д болон ҮОХ-дтой уулзах уулзалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа тогтмол зохион байгуулах. ОУОХ-ны Ерөнхийлөгч нь эдгээр уулзалтуудыг даргалан уулзалтын хөтөлбөрийг дээрхи уулзалтанд оролцох холбоодуудтай зөвшөлцөж тогтоож батална.
- 3.12 ОУОХ-ны хэргэм, цол, зэрэг, өргөмжлөлийг зөвшөлцөнө.
- 3.13 Олимпийн харт болон бусад хуулиар заагдаагүй бүх эрх мэдэл, үүрэг хариуцлагыг Чуулган болон Ерөнхийлөгчид даалгахгүй хариуцах, биелүүлэх

4. Эрх мэдлийг шилжүүлэх:

ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь эрх мэдлээ өөрийн нэг болон хэсэг гишүүдэд, ОУОХ-ны Хороодод, ОУОХ-ны зохион байгуулалтын албанд, бусад байгууллага болон гуравдагч этгээдэд эрх мэдлээ шилжүүлэн хэрэгжүүлж болно.

Дүрмийн 19-д хамаарах заалтууд

1. Ерөнхийлөгч нь ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн бүх хурлыг бэлтгэх, зохион байгуулах ажлыг хариуцана. Гэхдээ Ерөнхийлөгч нь энэхүү эрх мэдэл, ажил үүргээ бүхлээр нь эсвэл хэсэгчлэн Ерөнхий захиралд шилжүүлэн өгч болно.
2. Ерөнхийлөгч ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулна эсвэл гишүүдийн олонхийн хүсэлтээр араваас доошгүй

өдрийн өмнө зарлан хуралдуулж болно. Хурлын зарыг хурлаар хэлэлцэх асуудалын жагсаалттай хамт хүргүүлнэ.

3. Хүндэтгэх шалтгааны улмаас Ерөнхийлөгч ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн хуралд оролцож чадахгүй бол дэд ерөнхийлөгч, хэрэв мөн дээрхийн адил шалтгаанаар дэд ерөнхийлөгч оролцож чадахгүй бол ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн ахлах гишүүн нь хуралдааныг даргалана.
4. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн хурал нь гишүүдийн наймаас доошгүй ирцтэй байж хүчин төгөлдөр болно.
5. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн хурлын шийдвэр нь олонхийн санал дээр үндэслэгдэн гарна.
6. Гишүүн бүр нэг саналын эрхтэй. Түдгэлзсэн, хоосон орхисон, эсвэл гэмтсэн саналын хуудасуудыг хүчингүйд тооцно. Саналыг итгэмжлэлээр төлөөлөн өгөхийг хориглоно. Олимпийн Харт дагуу эсвэл хэрэв чуулганд оролцож буй бүх гишүүдийн дөрөвний нэг хувийн хүсэлтээр саналыг нууцаар авах эсэхийг Чуулганы дарга шийдвэрлэнэ. Хэрэв санал тэнцвэл Чуулганы дарга шийдвэр гаргана.
7. Дүрмийн 18.5 дахь нөхцөл байдалд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүнийг сонгуульд санал өгөхийг хориглоно.
Хэрэв гишүүний санал хураалтанд саналаа өгч болох үгүй эсэх нь эргэлзээтэй бол хурлын дарга шийдвэр гаргана.
8. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн хурлын явц, ажиллагааны талаар Олимпийн Хартаанд тусгагдаагүй бол үүнийг Ерөнхийлөгч тогтоож батална.
9. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн хурал утсан, теле болон дүрстэй видео дэлгэцэн хэлбэрээ алсаас хийгдэж болно.
10. Яаралтай тохиолдолд Ерөнхийлөгч нь ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүдийн тогтоол шийдвэр саналыг электрон шуудан, факс гэх мэт холбоогоор дамжуулан авч болно.
11. Бүх хурал, уулзалтууд түүний үйл явц, хөтөлбөрийг ОУОХ-ны Ерөнхийлөгчийн зөвшөөрөлөөр тогтооно.

20 ЕРӨНХИЙЛӨГЧ*

1. Ерөнхийлөгчийг гишүүдээс нууц санал хурааж Чуулганаар сонгоно. Ерөнхийлөгч нь найман жилийн хугацаатай сонгогдож дахин нэг удаа улирч дөрвөн жил сонгогдож болно.
2. Ерөнхийлөгч нь ОУОХ-г бүрэн эрхтэй төлөөлж, бүх үйл ажиллагааг удирдан явуулна.
3. Ерөнхийлөгч нь Чуулган, ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн гаргах шийдвэрээс өмнө ОУОХ-ны нэрийн өмнөөс аливаа арга хэмжээг авч, шийдвэр гаргаж болно. Хэрэв ийм арга хэмжээ авч, шийдвэр гаргасан тохиолдолд яаралтай хамаарах эрх бүхий байгууллагад хандан зөвшөөрөл авч баталгаажуулна.
4. Хэрэв Ерөнхийлөгч ажил үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд дэд ерөнхийлөгч түүний биеийг сайжирч ажилдаа ортол хэрэв урт хуагцаагаар өвдсэн тохиолдолд дараагийн Чуулганаар шинэ Ерөнхийлөгчийг сонготол ерөнхийлөгчийг орлоно. Шинээр сонгогдсон Ерөнхийлөгч нь найман жилээр эрх барьж дахин нэг удаа дөрвөн жилээр улиран сонгогдож болно.

Дүрмийн 20-д хамаарах заалтууд

Чуулган эхлэж сонгууль явагдахаас гурван сарын өмнө Ерөнхийлөгчид нэр дэвшигчдийг зарлана. Хэрэв нөхцөл байдлыг зөвтгөн тайлбарлах шалтгаантай бол ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн шийдвэрээр дээрхи хугацааг өөрчилж болно.

21 ОУОХ-ны Хороод /комисс/*

ОУОХ-ны Хороодыг тухайн байдлаас шалтгаалан Чуулган, ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл болон Ерөнхийлөгчид зөвөлгөө, зөвлөмж өгөх зорилгоор байгуулладаг. Ерөнхийлөгч нь шаардлагатай гэж үзвэл байнгын болон түр зуурын байнгын хороо, ажлын албадуудыг байгуулдаг. Олимпийн хартаар

тухайлан заагүй, ОУОХ-ноос дүрэм журамыг нь онцгойлон тогтоогүй бол Ерөнхийлөгч нь хороодын гишүүдийг томилож, мөрдөх журмыг тогтоож, хороог ажил үүргээ амжилттай гүйцэтгэсэн гэж үзвэл татан буулгаж болно. Олимпийн хартаар тухайлан заагүй, ОУОХ-ноос дүрэм журамыг нь онцгойлон тогтоогүй бол бүх хороод, байнгын хорооны хурал, зөвөлгөөн Ерөнхийлөгчтэй урьдчилан зөвшөлцөж байж хийгдэнэ. Ерөнхийлөгч нь бүх хороод, ажлын албадын гишүүн байх бөгөөд тэдгээрийн хурал зөвөлгөөнд оролцохдоо тэргүүлэх эрхтэй байна.

Дүрмийн 21-д хамаарах заалтууд

1. ОУОХ-ны Тамирчдын хороо:

ОУОХ-ны тамирчдын хорооны гишүүдийг ихэвчлэн Олимпийн тоглолтонд оролцож буй тамирчдаас бүрдүүлнэ.

Тамирчдын хорооны гишүүнийг сонгох сонгууль ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргасан дүрэм зааврын дагуу ОУОХ-ны тамирчдын хороотой зөвлөлдөж Олимпийн тоглолт болохоос нэг жилээс доошгүй хугацаанд ОУХ-д болон ҮОХ-дод мэдэгдэсний дараа Зуны болон Өвлийн Олимпийн тоглолтын үеэр сонгуулийг хийнэ.

ОУОХ-ны тамирчдын хорооны дүрэм, журам заавар нь ОУОХ-ны тамирчдын хороотой зөвлөлдөж байж ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр баталгаажна.

2. ОУОХ-ны Ёс зүйн хороо:

ОУОХ-ын Ёс зүйн хороог дүрмийн 22 болон түүнд хамаарах заалтуудын дагуу бүрдүүлнэ.

3. ОУОХ-ны Сонгуульд нэр дэвшүүлэх, магадлан тодорхойлох хороо

ОУОХ-ны гишүүний сонгуульд бүх нэр дэвшигчдийг шалгах, хянах үүднээс дүрмийн 16.2.3 заалтын дагуу ОУОХ-ны Сонгуульд нэр дэвшүүлэх хороог байгуулна.

ОУОХ-ны Ёс зүйн хорооны дүрэм, журам заавар нь ОУОХ-ны Ёс зүйн хороотой зөвлөлдөж байж ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр баталгаажна.

4. Олимпийн Эв санааны нэгдлийн хороо:

Олимпийн Эв санааны нэгдлийн хороо нь дүрмийн 5 болон түүнд хамаарах заалтуудад тусгагдсан үүргийг гүйцэтгэх зорилгоор байгуулагдана.

5. Нэр дэвшигч хотыг үнэлэх, цэгнэх хороо:

Зуны болон Өвлийн Олимпийн тоглолтоныг зохион байгуулахад нэр дэвших хотуудад шалгах, хянах зорилгоор Дүрмийн 33.2.2 заалтын дагуу Ерөнхийлөгч Нэр дэвшигч хотыг үнэлэх, цэгнэх хоёр хороог байгуулна.

6. Олимпийннаадмыг зохицуулах хороо:

Олимпийн наадмын зохион байгуулалтыг сайжруулах, чанартай явуулах ОУОХ, ОНЗБХ, ОСУХ, ҮОХ-дийн хоорондын хамтын ажиллагааг уялдуулах зорилгоор Ерөнхийлөгч нь дүрмийн 37 болон түүнд хамаарах заалтуудын дагуу Олимпийн наадмыг зохицуулах хороог байгуулна.

7. ОУОХ-ны Эрүүл мэндийн хороо*

7.1 Ерөнхийлөгч нь дараахь зорилгоор Эрүүл мэндийн хороог байгуулна:

7.1.1 Дэлхийн сэргээшийн эсрэг дүрэм журам болон бусад бүх сэргээшийн эсрэг журмуудыг, ялангуяа Олимпийн наадмын үеэр мөрдөх, биелүүлэх

7.1.2 Тамирчдын эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээнд анхаарч боловсронгуй болгох

7.2 Олимпийн наадмын үеэр Эрүүл мэндийн хорооны гишүүд нь энэхүү чиглэлээр эрх мэдлээ ашиглан Дэлхийн сэргээшийн эсрэг дүрмийг зөрчих, үл дагах асуудлаар өөрийн улсын ҮОХ-дийн төлөөлөгчидтэй ярилцах, хэлэлцэхийг хориглоно.

8. Журам:

12. Бүх ОУОХ-ны Хороодыг ОУОХ-ны гишүүн даргална. ОУОХ-ны хороодын хурал утсан болон дүрстэй видео дэлгэц хэлбэрээ алсаас хийгдэж болно.

22 ОУОХ-ны Ёс зүйн хороо*

ОУОХ-ны Ёс зүйн хороо нь Олимпийн хартын хэсэг болсон Ёс зүйн дүрэм болон ёс зүйн үндсэн зарчимуудыг тодорхойлох, шинэчлэх ажил үүрэгтэй. Үүнээс гадна Ёс зүйн дүрмийг зөрчсөн, ёс зүйн үндсэн зарчмуудыг хүндэтгээгүй аливаа гомдол саналыг шалган судлаж хэрэв шаардлагатай гэж үзвэл ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд шийтгэл хүлээлгэн, хориг тавих саналыг оруулна.

Дүрмийн 22-д хамаарах заалт

1. ОУОХ-ны Ёс зүйн хорооны бүтэц, зохион байгуулалт нь өөрийн хууль, дүрмээр дагуу байна.
2. ОУОХ-ны Ёс зүйн хорооноос Ёс зүйн дүрэм, Ёс зүйн хорооны журам болон бусад бүх дүрэм журам, заалтанд өөрчлөлт хийх, түүнийгээ хэрэгжүүлэх болсон тохиолдолд заавал ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр батлуулна.

23. Албан ёсны хэл

1. ОУОХ-ны албан ёсны хэл нь Франц болон англи хэл байна.
2. Бүх Чуулганууд нь Франц, Англи, Герман, Испани, Орос болон Араб хэл дээр шууд орчуулгатай явагдана.
3. Хэрэв Олимпийн харти болон бусад ОУОХ-ны бичиг баримтанд Франц болон Англи хооронд утгын ялгаа, зөрөө гарвал бичгээр тухайлан заагаагүй бол Франц утгыг давамгайлсан хэрэглэнэ.

24. ОУОХ-ны Хөрөнгө санхүү

1. ОУОХ нь гэрээсээр өвлүүлж буй хөрөнгө, бэлэг сэлт зэрэгийг хүлээн авч болохын зэрэгцээ үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор бусад хэлбэрээр хөрөнгөтэй болж болно. Мөн Олимпийн эд хөрөнгө, бусад эрх зөвшөөрлүүдийг телевизүүдэд өгөх, ивээн тэтгэгчид болон Олимпийн наадмаас орох орлогоор хөрөнгөө бүрдүүлж болно.

2. Олимпийн Хөдөлгөөний хөгжлийг идэвхижүүлэх, сайжруулах зорилгоор ОУОХ нь олсон орлогоос ҮОХд, ОУСХ-д болон Олимпийн Эв нэгдлийн сан, ОНЗБХ-нд тэтгэлэг, мөнгөн тусламж үзүүлж болно.

3 ОЛОН УЛСЫН СПОРТЫН ХОЛБООД / ОУСХд /

25 Олон Улсын Спортын Холбоодыг хүлээн зөвшөөрөх нь

Олимпийн Хөдөлгөөнийг хөгжүүлэх, идэвхижүүлэх зорилгоор ОУОХ нь дэлхийн түвшинд нэг болон хэд хэдэн спортын зохион байгуулалт, үйл ажиллагааг удирдан явуулдаг улмаар тухайн спортоор үндэсний байгууллагууд нь үйл ажиллагаа явуулдаг олон улсын чанартай засгийн газрын бус байгууллагуудыг ОУСХ-д хэмээн хүлээн зөвшөөрч болно.

ОУСХ-дийн хууль, дүрэм журам, үйл ажиллагаа нь Олимпийн хөдөлгөөний хүрээнд Олимпийн хартанд нийцэж Дэлхийн Сэргээшийн Эсрэг дүрмийн биелүүлэн ажилна. Дээрхи заалтыг биелүүлэн ажиллахын зэрэгцээ бүх ОУСХ-д бүрэн бие даасан байж тухайн спортын үйл ажиллагааг бие даан удирдан явуулна.

26 Олимпийн Хөдөлгөөн дахь ОУСХ-дийн эрхэм зорилго, үүрэг

1. Олимпийн Хөдөлгөөн дахь ОУСХ-дийн эрхэм зорилго, үүрэгүүд нь:
 - 1.1 Олимпийн үзэл санааны дагуу тухайн спортынхоо дүрэм журамыг тогтоон түүнийг хэрэгжүүлэх
 - 1.2 Тухайн спортоо дэлхий дахинд хөгжүүлэх
 - 1.3 Олимпийн хартанд тусгагдсан зорилтууд, ялангуяа Олимпизм, Олимпийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд чиглэгдсэн зорилтуудыг биелүүлэхэд туслах
 - 1.4 Олимпийн наадмыг зохион байгуулах хотод нэр дэвшигчидэд ялангуяа мэргэжлийнхээ үүднээс тухайн спортынхоо байгууламжынх нь талаар саналаа илэрхийлэх

- 1.5 Олимпийн хартанд нийцүүлж тухайн спортын төрлөөр Олимпийн наадамд сонгогдон оролцох шалгуурыг тогтоож ОУОХ-гоор батлуулах
 - 1.6 Олимпийн наадамд ОУОХ-ны ивээл доор явагдаж буй тухайн спортын тэмцээнийг мэргэжлийн үүднээс удирдан зохион байгуулж, техникийн хяналтыг хариуцах
 - 1.7 Олимпийн эв санааны нэгдэлийн хөтөлбөрүүдийг хэрэгжихэд мэргэжлийн, техник туслалцаа үзүүлэх
2. Түүнчлэн ОУСХ-д нь дараахь эрхтэй:
 - 2.1 Олимпийн хөдөлгөөн болон Олимпийн хартын талаар санал боловсруулж ОУОХ-д өргөн барих
 - 2.2 Олимпийн Конгрессийн бэлтгэл ажилд хамтран ажиллах
 - 2.3 ОУОХ-ны хүсэлтийн дагуу ОУОХ-ны Хороодын үйл ажиллагаанд оролцох

4 ҮНДЭСНИЙ ОЛИМПИЙН ХОРОО / ҮОХд /

1. ҮОХ-дийн эрхэм зорилго нь тухайн улсдаа Олимпийн Хартын дагуу Олимпийн хөдөлгөөнийг хөгжүүлэх, хамгаалах, сурталчилан дэлгэрүүлэхэд оршино.
2. **ҮОХ-дийн үүрэг:**
 - 2.1 Тухайн улсын нутаг дэвсгэрт Олимпийн хөдөлгөөний соёл, боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, Үндэсний Олимпийн академи, Олимпийн музей зэрэг Олимпийн боловсрол олгох байгууллагуудыг шинээр байгуулагдахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх, бүх шатны сургууль, биеийн тамир спортын сургууль, институт, их дээд сургуулиудад Олимпийн боловсролын хөтөлбөрийг сурталчилан дэлгэрүүлэх зэрэг биеийн тамир спорт, боловсролын байгуулагуудад Олимпизмийн үзэл санаа түүний үндсэн зарчимуудыг сурталчилан дэлгэрүүлэх
 - 2.2 Тухайн улсын нутаг дэвсгэрт Олимпийн Хартийн мөрдүүлж, хэрэгжилтэнд хяналт тавих
 - 2.3 Өндөр амжилт үзүүлдэг спортын төрлүүд болон бусад нийтийг хамарсан спортын төрлүүдийг хөгжихөд дэмжлэг үзүүлэх

2.4 Олимпизмийн үндсэн зарчимуудыг түгээн дэлгэрүүлэх, сурталчилах зорилгоор спортын байгууллагын ажилчид, зохион байгуулагчдад дэмжлэг үзүүлж, сургалт зохион байгуулж дадлагажуулах

2.5 Спортод бүх хэлбэрийн ялгаварлан гадуурхах, хүчирхийлэлийн хэлбэрийг эсэргүүцэж, идэвхитэй тэмцэх

2.6 Дэлхийн Сэргээшийн эсрэг агентлагийн дүрмийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэх

2.7 Тамирчдын эрүүл мэнд болон эмнэлгийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг дэмжих, тусламж үзүүлэх

3. ҮОХ-д нь Олимпийн наадам болон ОУОХ-ны ивээл дор спортын олон төрлөөр зохион байгуулагддаг бүс, тив, дэлхийн чанартай тэмцээнүүдэд тухайн улсаа онцгой эрхтэйгээр төлөөлөн оролцоно. Үүний зэрэгцээ ҮОХ-д нь Олимпийн наадамд баг тамирчдаа зохион байгуулан оролцуулах үүрэгтэй.

4. ҮОХ-д нь тухайн улсаа Олимпийн тоглолтыг зохион байгуулах хотыг сонгон шалгаруулах, нэрлэх онцгой эрхтэй.

5. ҮОХ-д нь эрхэм зорилгоо биелүүлэх үүднээс засгийн газрын байгууллагуудтай харилцан, хамтран ажиллаж болно. Гэхдээ Олимпийн Харттай зөрчилдөх аливаа үйл ажиллагаанд оролцож, хамтарч болохгүй. ҮОХ-д нь мөн төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болно.

6. ҮОХ-д нь бие даасан байдлаа бүрэн хангаж улс төр, хууль эрх зүй, шашин, бизнесийн аливаа дарамт шахалтыг эсэргүүцэж хараат бус байна.

7. ҮОХ-д дараахь эрхтэй:

7.1 Байгууллагадаа “Үндэсний Олимпийн Хороо” гэсэн нэр өгч улсын нэрээ бусдаас ялгахын тулд хамт оруулж болно.

7.2 Олимпийн Хартын дагуу Олимпийн наадамд баг тамирчид, албан ёсны хүмүүс, төлөөлөгчдөө оролцуулах

7.3 Олимпийн Эв санааны нэгдлийн сангаас туслалцаа, дэмжлэг авах

- 7.4 ОУОХ-ны зөвшөөрлөтөйгөөр дүрмийн 7-14 болон түүнд хамаарах заалтуудын дагуу Олимпийн зарим эд хөрөнгө, өмч, билэгдэлийг хэрэглэх
- 7.5 ОУОХ-ны ивээл дор зохиогдох Тоглолтууд, арга хэмжээнүүдэд оролцох
- 7.6 ОУОХ-ноос хүлээн зөвшөөрсөн ҮОХ-дийн зөвлөлд хамрагдах
- 7.7 Олимпийн Харт, Олимпийн Хөдөлгөөн болон Олимпийн наадмын зохион байгуулалтын талаар саналаа боловсруулж ОУОХ-нд өргөн барих
- 7.8 Олимпийн наадмыг зохион байгуулах нэр дэвшигчдийн талаар санал бодлоо илэрхийлэх
- 7.9 ОУОХ-ны хүсэлтийн дагуу ОУОХ-ны хороодын үйл ажиллагаанд оролцох
- 7.10 Олимпийн Конгрессийн бэлтгэл ажилд хамтран оролцох
- 7.11 Олимпийн Хартид заасан болон ОУОХ-ноос олгосон бусад эрхийг эдлэх

8. ОУОХ өөрийн хэлтэс, салбарууд болон Олимпийн эв санааны нэгдлийн сангаар дамжуулан ҮОХ-дод эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд нь туслана.

9. Хэрэв тухайн улсын хэрэгжүүлж буй хууль тогтоомж, дүрэм журам, засгийн газрын болон бусад эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа, илэрхийлэлүүд нь тухайн улсын ҮОХ-ны үйл ажиллагаанд саад болж Олимпийн Хартыг зөрчин түүнтэй харшилдаж байна гэж үзвэл ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс Олимпийн Хөдөлгөөнөө хамгаалах зорилгоор тухайн улсын ҮОХ-г гишүүнээс түдгэлзүүлэх, гишүүнчлэлийг зогсоох зэрэг боломжит бүх арга хэмжээ шийтгэлийг хэрэгжүүлнэ. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс ийм шийдвэр гаргахаас өмнө тухайн ҮОХ-нд тайлбар хийх боломжыг олгоно.

29 ҮОХ-дын бүтэц, бүрэлдэхүүн*

1. ҮОХ-д нь бүтэц, бүрэлдэхүүнээс үл хамааран дараахь нэгжүүдийг заавал оруулна:

- 1.1 Хэрэв тухайн улс оронд ОУОХ-ны гишүүд байвал тэднийг бүрэлдэхүүндээ оруулна. Эдгээр гишүүд ҮОХ-ны чуулганы санал хураалтанд оролцох эрхтэй байна. Түүнээс гадна дүрмийн 16-ийн 1.1.1

болон 16-ийн 1.1.2 зүйлд заасны дагуу тухайн улс оронд байгаа ОУОХ-ны гишүүд нь албан тушаалаараа мөн ҮОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн байж санал өгөх эрхтэй.

1.2 Олимпийн наадмын хөтөлбөрт багтах спортын төрлүүд эсвэл ОУСХ-дын томилсон төлөөлөгчид ҮОХ-ны гишүүн байна. Гэхдээ тухайн спортын төрөл нь тэдгээрийг удирдах ОУСХ-дын гишүүн байна.

1.3 Олимпийн Наадамд оролцсон тамирчдын төлөөлөлөөс сонгоно. Тэд сүүлчийн оролцсон Олимпийн Наадмаас хойшхи гурав дахь Олимпийн Наадам өнгөрсөн тохиолдолд сонгуульт албаа орхих ёстой. ҮОХ-ны хүсэлтийг үндэслэн Олимпийн наадамд төлөөлөгчид нь оролцох ёстой гэсэн нөхцөлийг ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөл нь чөлөөлж болно.

2 ҮОХ-д нь гишүүдээр мөн дараахь нэгжүүдийг оруулж болно:

2.1 ОУОХ-нь хүлээн зөвшөөрсөн боловч Олимпийн наадмын хөтөлбөрт ордоггүй гэхдээ ОУСХ-ны гишүүн үндэсний холбоодыг

2.2 Спортын олон төрлийг хамарсан цогцолбор болон спортын чиглэлийн байгууллагууд, тэдгээрийн төлөөлөгчид, мөн ҮОХ-ны үйл ажиллагааг дэмжин саначлагатай ажиллаж байгаа эсвэл спорт Олимпизмийг хөгжүүлэхэд гарамгай хувь нэмэр оруулсан тухайн улс орны иргэдийг

3. ҮОХ-ны гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын санал хураалтанд оролцогчдын олонхийг дүрмийн 1.2-т заасан Үндэсний спортын холбоод болон тэдний төлөөлөл бүрдүүлнэ. Олимпийн наадамтай холбоотой асуудлыг хэлэлцэж санал хураахад зөвхөн ҮОХ-ны гүйцэтгэх удирдлагын гишүүдийн болон дээрх 1.2-т заасан үндэсний спортын холбоодын саналыг тооцно. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс баталж өгсөний дагуу ҮОХ болон Олимпийн наадамтай холбоотой асуудлаарх санал хураалтанд оролцогчдын олонхид дүрмийн 1.1-т заасан тухайн оронд байх ОУОХ-ны гишүүд болон 1.3-т тодорхойлсон тамирчдын төлөөлөлийг оруулж болно.

4. Засгийн Газар буюу төрийн бусад байгууллагууд ҮОХ-ны гишүүдийг томилохгүй. Гэхдээ ҮОХ нь эдгээр байгууллагын төлөөлөгчдийг өөрийн үзэмжээр гишүүнээрээ сонгох шийдвэр гаргаж болно.
5. ҮОХ-ны эрх зүйн хэм хэмжээ, эрх мэдлийн хүрээ нь түүний байгуулагдсан болон төв нь байдаг улс орны хууль, холбогдох журмын дагуу тогтоосон хүрээнд байх ёстой.

Дүрмийн 28 болон 29-д хамаарах заалтууд

1. ҮОХ-г хүлээн зөвшөөрөх журам

- 1.1 Үндэсний Спортын байгууллагууд нь ҮОХ болж ОУОХ-ны гишүүнээр хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дүрмийн 29-р зүйл түүнд хамаарах 28, 29-р заалтууд болон Олимпийн Хартад тусгагдсан бусад нөхцөл болзолуудыг хангасанаа батлан харуулсан албан бичгүүдийг бүрдүүлж өгнө.
- 1.2 Энэхүү баталсан бичиг баримтанд мөн тухайн ҮОХ-ны гишүүн үндэсний спортын холбоод нь өөрийн улсад болон Олон улсын хэмжээнд тодорхой бодит спортын үйл ажиллагаа явуулдаг, ялангуяа уралдаан тэмцээн зохион байгуулдаг, оролцдог, тамирчид нь тогтмол бэлтгэл сургуулилалт хийдгийг нотлох баримт байх хэрэгтэй. ҮОХ нь ОУСХ-ны гишүүнчлэлтэй түүний харъяалалд үйл ажиллагаа явуулдаг тухайн спортын зөвхөн нэг үндэсний холбоог хүлээн зөвшөөрч болно. Тухайн ҮОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн эдгээр үндэсний холбоод буюу тэдгээрийн сонгосон төлөөлөгчид нь ҮОХ болон түүний гүйцэтгэх байгууллагын санал хураалтанд оролцогчдын олонхийг бүрдүүлэх ёстой. ҮОХ-ны бүрэлдэхүүнд багтаж байдаг үндэсний спортын холбоодоос доод тал нь таван холбоо Олимпийн наадмын хөтөлбөрт орсон спортын төрлүүдийг удирдах тухайн ОУСХ-дын гишүүн байх шаардлагатай.
- 1.3 ОУОХ-нд гишүүнээр элсэхийн тулд өргөдөл гаргаж байгаа ҮОХ нь ОУОХ-гоор Дүрмээ хянуулан батлуулах ёстой. ҮОХ-ны батлуулсан дүрэмд өөрчлөлт, нэмэлт хийх бол энэ талаар ОУОХ-нд мэдэгдэн түүнийг зөвшөөрүүлнэ. ҮОХ-дын дүрэм нь Олимпийн Хартид ямагт нийцэж

түүний утга санааг тод тусгасан байх ёстой. ҮОХ-ны дүрмийн утга санаа, мөн орчуулга, тайлбарын тухайд эргэлзэх зүйл гарч эсвэл дүрэм нь Олимпийн Хартиас зөрөх тохиолдолд Олимпийн Хартийг мөрдөнө.

- 1.4 ҮОХ тус бүр ҮОХ-ны дүрмийн дагуу бүх гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна. ҮОХ-ны бүх гишүүдийн хурлаар жилийн ажлын тайлан, аудитаар баталсан санхүүгийн тайлан болон зарим тохиолдолд гүйцэтгэх байгууллагын албан тушаалтан, гишүүдийг сонгох зэрэг асуудлыг хэлэлцэнэ.
- 1.5 ҮОХ-ны гүйцэтгэх байгууллагын албан тушаалтан, гишүүдийг ҮОХ-ны Дүрмийн дагуу дөрвөн жилээс хэтрэхгүй хугацаагаар сонгох ба тэд Чуулганаар дахин сонгогдож болно.
- 1.6 Спортын захиргааны байгууллагад мэргэжлийн чиглэлээр ажиллаж буй хүмүүсээс бусад ҮОХ-ны гишүүд ажил үүрэг гүйцэтгэсний төлөө ямар нэг цалин, шагнал авах ёсгүй. Гэхдээ тэдний томилолтоор ажиллахад зарцуулсан замын, байрны болон зайлшгүй шаардлагатай өөр бусад зардлыг нь нөхөн олгож болно.
- 1.7 ҮОХ-д нь ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн эрхээ түр эсвэл бүрмөсөн цуцлуулсан тохиолдолд Олимпийн Харти болон ОУОХ-ноос олгосон бүх эрхээ алдана.

2. ҮОХ-дын зорилтууд

ҮОХ-д нь доорхи зорилтуудыг биелүүлэн ажиллана:

- 2.1 Олимпийн наадамд болон ОУОХ-ны ивээл дор спортын олон төрлөөр зохион явуулах бүсийн, тивийн, дэлхийн хэмжээний тэмцээнд оролцох өөрийн баг төлөөлөгчдийг бүрдүүлж, удирдан оролцох. Оролцох тамирчдын тоо, мэдүүлэгийг тухайн үндэсний спортын холбоодын гаргасан санал дээр үндэслэн шийднэ. Тамирчдыг тэмцээнд сонгон шалгаруулж оролцуулах үйл явц нь тухайн тамирчны зөвхөн спортын амжилтаар бус мөн тухайн тамирчин улс эх орныхоо залуу үед хэрхэн үлгэр жишээ болж чадах чадварыг харгалзана. ҮОХ-д нь Үндэсний

- спортын холбоодоос санал болгож буй тоо мэдүүлэг нь Олимпийн Хартын бүх нөхцөл заалтуудыг хүндэтгэн дагаж байгаад хяналт тавина.
- 2.2 ҮОХ-д нь баг, төлөөлөгчдөө тээвэрлэлт, байр, хэрэглэл материалаар хангаж ажиллана. Мөн ҮОХ-д өөрсдийн баг тамирчид төлөөлөгчдийг өвчин эмгэг, эмнэлгийн болон эмийн зардал, үхэл, тахир дутуу болох явдал, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага зэрэг гэнэтийн эрсдэлийн боломжит даатгалын гэрээ хийнэ. Мөн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд байгаа хүмүүсийн сахилга батын асуудлыг хариуцна.
- 2.3 ҮОХ-д нь өөрсдийн баг, тамирчид, төлөөлөгчдийг Олимпийн Наадамд болон тэмцээн уралдаан, ёслолын арга хэмжээнд ямар хувцас, форм өмсөх, ямар хэрэглэл материал ашиглах талаар удирдамж өгөх, шийдвэрлэх онцгой эрхтэй. Энэхүү онцгой эрх нь тэмцээн уралдааны үед баг тамирчдын хэрэглэх тусгай тоног төхөөрөмж, хэрэглэл материалд хамаарахгүй. Тамирчдын тэмцээнд хэрэглэх тусгай тоног төхөөрөмж, хэрэглэл материал нь үйлдвэрлэлийн онцгой шинж чанараас шалтгаалж тамирчдын тоглолт ур чадварт нөлөөлдөг тул тухайн ҮОХ-доор шалгагдаж хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой. Тэмцээнд хэрэглэх тусгай тоног төхөөрөмж, хэрэглэл материал нь Олимпийн наадмын үеэр хэрэглэж болох эсэх талаар ҮОХ-д нь шалган нягталж баталгаажуулна.
- 2.4 ҮОХ-д нь өөрийн улсын нутаг дэвсгэрт Олимпийн эд хөрөнгө, өмчийг хамгаалахад ОУОХ-нд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллана.

3. Зөвлөмж:

ҮОХ-д нь дор дурдсан зүйлийг биелүүлэх нь зүйтэй:

- 3.1 Олимпийн хөдөлгөөний дэмжих, түгээн дэлгэрүүлэх зорилгоор боломжтой бол жил бүр Олимпийн өдөр эсвэл долоо хоногийн аяныг тогтмол зохион явуулж байх
- 3.2 Спорт, Олимпизмийн үйл ажиллагаандаа соёл урлагийг оруулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх
- 3.3 Олимпийн эв санааны нэгдлийн хөтөлбөрүүдэд оролцох

3.4 Олимпизмийн үндсэн зарчмуудад нийцүүлэн санхүүжилтийн эх үүсвэрийг эрэлхийлэх

29. Үндэсний спортын холбоод

Үндэсний спортын холбоод ҮОХ-гоор зөвшөөрүүлж гишүүн нь болохын тулд спортын бодит тодорхой, тасралтгүй үйл ажиллагаа явуулдаг, ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн ОУСХ-ны гишүүн байж, мөн Олимпийн Харти болон тухайн харъяалагдах ОУСХ-ны дүрмийн дагуу ажилладаг байх ёстой.

30. Улс ба ҮОХ-ны нэр

1. Олимпийн Хартид байгаа “улс” гэдэг ойлголт нь олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн тусгаар тогтносон улс гэсэн утгыг илэрхийлнэ.

2. ҮОХ-ны нэр нь түүний нутаг дэвсгэрийн хил хязгаар, улс орных нь өв уламжлалтай харилцан хамраалтай нийцэж ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөр баталгаажсан байх ёстой.

31. ҮОХ-ны далбаа, эмблем, дуулал

ҮОХ-д нь Олимпийн тоглолт болон бусад арга хэмжээ, үйл ажиллагаандаа ашиглах батламжилсан далбаа, эмблем, дуулалтай байж болох бөгөөд тэдгээрийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр батлуулах ёстой.

БҮЛЭГ 5

ОЛИМПИЙН НААДАМ

I. ОЛИМПИЙН НААДМЫГ УДИРДАХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТЭМДЭГЛЭХ

32. Олимпийн наадмыг зохион явуулах, тэмдэглэх нь

1. Олимпийн зуны их наадам олимпийн мөчлөгийн эхний жилд, өвлийн их наадам нь 3 дахь жилд тус тус зохион байгуулагдана.
2. ОУОХ-ноос Олимпийн наадмыг зохион байгуулахаар тодорсон хот Олимпийн наадам зохион явуулах нэр хүндтэй, хариуцлагатай үүрэг хүлээнэ.
3. Олимпийн наадам хийх товыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс тодорхойлно.
4. Олимпийн наадам товлосон жилдээ хийгдэхгүй бол зохион байгуулагч хотын эрхийг хүчингүй болгоно харин ОУОХ-ны эдлэх бусад эрхүүд нь үүгээр хязгаарлагдахгүй.
5. ОНЗБХ, Олимпийн наадмыг зохион байгуулагч хот болон тухайн ҮОХ нь Олимпийн наадмыг зохион байгуулж тэмдэглэн өнгөрүүлсэнтэйгээр холбоотой олсон нийт ашигаа Олимпийн хөдөлгөөн болон спортын хөгжилд зориулна.

Дүрмийн 32-д хамаарах заалт

Олимпийн наадмын үргэлжлэх хугацаа арван зургаан хоногоос хэтрэхгүй байна.

33. Зохион байгуулах хотыг сонгон шалгаруулах*

1. Олимпийн наадам зохион байгуулах хотыг сонгон шалгаруулах нь ОУОХ-ны Чуулганы онцгой эрх юм.
2. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь зохион байгуулах хотыг сонгон шалгаруулах Чуулган болтол мөрдөх сонгон шалгаруулалтын журмыг боловсруулна. Онцгой тохиолдол гарахгүй бол зохион байгуулагч хотыг наадам болохоос долоон жилийн өмнө тодруулна.
3. Сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлтээ гаргасан хот, улсын засгийн газар болон тухайн улсын холбогдох байгуулагууд нь Олимпийн хартийг хүндэтгэн даган мөрдөхөө баталж буйгаа бичгээр ОУОХ-нд албан ёсоор өргөн барина.

4. Олимпийн наадмыг зохион байгуулах хотыг сонгон шалгаруулах Чуулган нь олимпийн наадам зохион байгуулахаар нэрээ дэвшүүлээгүй улсад хуралдана.

Дүрмийн 33-д хамаарах заалтууд

1. Олимпийн наадмыг зохион байгуулахаар нэрээ дэвшүүлэх - Нэр дэвшиж буй хотууд
 - 1.1 Олимпийн наадмыг зохион байгуулахаар нэрээ дэвшүүлж буй хот нь нэрээ дэвшүүлж байгаагаа хүлээн зөвшөөрүүлэхийн тулд эхэлж тухайн улсынхаа ҮОХ нь баталгаажуулна.
 - 1.2 Нэр дэвшигч хотын эрх мэдэл бүхий засаг захиргааны байгууллага өөрийн орны ҮОХ-ны дэмжлэг авсан бичгийн хамт Олимпийн наадмыг зохион байгуулах мэдүүлгээ ОУОХ-нд өргөн барина. Энэхүү хоёр байгууллага нь Олимпийн наадмыг ОУОХ-ноос тавьж буй шаардлага, болзлыг хангаж биелүүлж өндөр түвшинд зохион байгуулна гэсэн баталгааг гаргаж өгөх ёстой.
 - 1.3 Хэрэв нэг улсад хэд хэдэн хот Олимпийн наадмыг зохион байгуулахаар нэрээ дэвшүүлсэн байвал тэдгээрээс аль хотыг сонгож авах асуудлыг тухайн улсын ҮОХ нь шийдвэрлэнэ.
 - 1.4 Тухайн хотыг нэр дэвшүүлэх мэдүүлгийг ОУОХ-нд өгсөн өдрөөс эхлэн ҮОХ нь Олимпийн наадам зохион явуулах уг хотын үйл ажиллагаа, төлөв байдалд ажиглалт, хяналт хийж, хамтын хариуцлага хүлээх ёстой.
 - 1.5 Нэр дэвшигч хотууд нь Олимпийн харт, ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөлөөс гаргасан дүрэм шаардлагууд мөн түүнчлэн тухайн спортын ОУ-ын холбооноос баталсан гаргасан техникийн нормуудыг даган биелүүлэх үүрэг хүлээнэ.
 - 1.6 Нэр дэвшигч хотууд нь нэр дэвшигчийг хүлээн зөвшөөрөх дүрмийг дагаж мөрдөнө. Уг дүрмийг ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөл өөрийн эрх мэдлийн хүрээнд батална. ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөл аль хотыг нэр дэвшигч хотоор хүлээн зөвшөөрөх эсэхээ шийдвэрлэнэ.

2. Нэр дэвшигч хотуудад үнэлэлт өгөх

2.1 Нэр дэвшигч хотууд гэдэг нь мэдүүлгээ өгч ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн шийдвэрийн дагуу Чуулганы шалгаруулалтанд оролцох эрхээ авсан хотуудыг хэлнэ.

2.2 ОУОХ-ны ерөнхийлөгч нь тухайн олимпийн наадмыг зохион байгуулахаар нэр дэвшигч хотуудаас сонгон шалгаруулалт хийх үнэлгээний хороог байгуулна. Уг хороонд ОУОХ, ОУ-ын спортын холбоод, ҮОХ, Тамирчидын хороо, ОУ-ын паралимпын хорооны төлөөлөл багтана. Олимпийн наадам зохион байгуулахаар өөрийн хотын нэрийг дэвшүүлж буй улсын төлөөлөл сонгон шалгаруулалт хийх үнэлгээний хорооны бүрэлдхүүнд орох ёсгүй. Үнэлгээний хороо нь мэргэжлийн шинжээчдээс туслалцаа авч болно.

2.3 Үнэлэлт өгөх хороод нэр дэвших хотуудыг судалж, газар дээр нь очиж шалгаад, Олимпийн наадам зохион байгуулах хотыг сонгон тодруулах Чуулган хуралдахаасаа нэг сараас доошгүй хугацаанд нэр дэвшигч хот бүрийн тухай бичсэн тайлангаа ОУОХ-ны бүх гишүүдэд танилцуулсан байна.

2.4 Нэр дэвшигч хотууд ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөлийн шаардсан санхүүгийн баталгааг гаргаж өгөх ёстой. Уг баталгааг тухайн хот, орон нутгийн, бүсийн болон улсын эрх бүхий байгууллага эсвэл гуравдагч этгээд гаргаж өгч болно.

3 Зохион байгуулагч хотыг сонгон шалгаруулах, тэдгээртэй гэрээ байгуулах

3.1 Үнэлгээний хороо гаргасан тайлангаа ОУОХ-нд өргөн барьсаны дараа ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөл нь нэр дэвшигч хотуудын нэрсийн жагсаалтыг эцсийн байдлаар сонгон шалгаруулах Чуулганд өргөн барина.

3.2 Чуулган үнэлгээний хорооны гаргасан тайланг хэлэлцсэний дараа зохион байгуулах хотыг сонгон шалгаруулах санал хураалтыг явуулна.

3.3 ОУОХ нь олимпийн наадмыг зохион байгуулах хот болон тухайн улсын үндэсний олимпийн хороотой бичгээр гэрээ байгуулна. Уг гэрээг Олимпийн Наадмыг Зохион Байгуулах Хоттой Байгуулах Гэрээ гэх ба

гэрээг зохион байгуулагч хотыг шалгаруулахад оролцсон бүх талууд баталж, хэрэгжүүлнэ.

34. Олимпийн Наадмыг зохион явуулах газар, байгууламж

1. ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөлөөс зарим арга хэмжээг тухайн улсын өөр бусад хотын байгууламж, спорт цогцолборт явуулахыг тусгайлан заагаагүй бол Олимпийн наадмын спортын бүх уралдаан тэмцээнийг олимпийн наадмыг зохион зөвхөн байгуулагч хотод явуулна. Олимпийн нээлтийн болон хаалтын ёслол зөвхөн Олимпийн наадмыг зохион байгуулагч хотод болно. Спортын бүхий л арга хэмжээ болон бусад арга хэмжээг зохион байгуулах заал танхим, байгууламжыг ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөлөөс батална.
2. Өвлийн олимпийн наадмын хувьд газар зүйн болон байрлал зүйн онцлогоос шалтгаалан зарим арга хэмжээ болон спортын тодорхой төрлүүдийг зохион байгуулагч хотод явуулах боломжтой хэдий ч онцгой тохиолдолд уг арга хэмжээнүүдийг хөрш зэргэлдээ улс оронд зохион байгуулахыг ОУОХ зөвшөөрч болно.

Дүрмийн 34-д хамаарах заалтууд

1. Хэрэв зарим арга хэмжээ болон спортын тодорхой төрлүүдийг олимпийн наадмыг зохион байгуулагч хотоос өөр хот, байгууламжинд зохион байгуулахаар бол уг хүсэлтээ Үнэлгээний Хороог нэр дэвшигч хотод сүүлчийн удаа хүрэлцэн очихоос өмнө ОУОХ-нд бичгээр танилцуулна.
2. Хэдийгээр спортын зарим төрлийн уралдаан тэмцээн, бусад арга хэмжээнүүд олимпийг зохион байгуулагч хот болон хөрш зэргэлдээ хот, заал танхим, байгууламжинд явагдаж байгаагаас үл хамааран олимпийн наадмыг зохион байгуулах, хэвлэл мэдээллээр дамжуулах ажиллагаа ижил түвшинд байх ёстой.

35. Зохион байгуулах хороо

ОУОХ-ноос зохион байгуулагч хот харъяалагдах улсын ҮОХ, мөн зохион байгуулагч хотод Олимпийн наадам зохион байгуулах эрх олгоно. ҮОХ нь Зохион Байгуулах Хороог үүсгэн байгуулах үүрэг хүлээж хороо

байгуулагдсан өдрөөс эхлэн ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлтэй шууд харилцаж зааварчилгаа авч ажлаа тайлагнаж байна.

Дүрмийн 35-д хамаарах заалтууд

1. Зохион Байгуулах Хороо нь тухайн улсынхаа хуулийн этгээд байна.
2. Зохион Байгуулах Хорооны гүйцэтгэх удирдлагад:
 - Дүрмийн 16-р зүйлийн 1.1.1.1-д тодорхойлсон тухайн улс дахь ОУОХ-ны гишүүн буюу гишүүд
 - ҮОХ-ны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга
 - Зохион байгуулагч хотоос томилогдсон нэгээс цөөнгүй төлөөлөгч орно.
 - Зохион байгуулагч хотын удирдлагаас дор хаяж нэг гишүүн тус тус байна.Зохион байгуулах Хорооны гүйцэтгэх удирдлагад орон нутгийн засаг захиргааны эрх бүхий этгээд болон бусад нэр хүнд бүхий хүмүүс орж болно.
3. Зохион байгуулах Хороо нь үүсгэн байгуулагдахаас татан буугдах хүртлээ Олимпийн Харт, ОУОХ, ҮОХ зохион байгуулагч хотын хооронд байгуулсан гэрээ, ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөлөөс гаргасан бусад дүрэм зааврын дагуу өөрийн бүхий л үйл ажиллагааг явуулах үүрэг хүлээнэ.

36. Үүрэг ариуцлага- Олимпийн наадам зохион байгуулах эрхийг цуцлах

1. ҮОХ, ЗБХ, зохион байгуулах хот нь олимпийн наадмын зохион байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэхдээ гэрээнд тусгасан заалтуудыг биелүүлэх тал дээр тус тусдаа болон хамтарсан хариуцлага хүлээнэ. Харин Олимпийн наадам зохион байгуулж явуулах санхүүгийн хариуцлага, мөн Хартийн 33-р зүйлийн тайлбарт дурдсан аливаа баталгаатай холбоотой байж болох гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагыг зохион байгуулагч хот, ЗБХ хамтдаа болон тус тусдаа хүлээх болно. Энэ талаар ОУОХ санхүүгийн ямар ч хариуцлага хүлээхгүй.
2. Олимпийн харт, ОУОХ-ноос гаргасан бусад журам заавруудад нийцээгүй арга хэмжээ эсвэл ҮОХ, ЗБХороо, Зохион байгуулагч хот нь хүлээсэн үүргээ зөрчих тохиолдолд ОУОХ нь зохион байгуулагч хот, ЗБХороо, ҮОХ-оос Олимпийн наадам зохион байгуулах эрхийг ОУОХ-ноос нөхөн олговор олгохгүйгээр хэдийд ч нэн даруй цуцлах эрхтэй.

Ийм тохиолдолд ҮОХ, ЗБХороо, зохион байгуулагч хот, тухайн улс, түүний засгийн газар, эрх бүхий байгууллагууд, өөр бусад этгээд нь хот, орон нутаг, улс аймаг бусад бүсийн болон үндэсний түвшинд ОУОХ-ны эсрэг ямар нэгэн нөхөн олговор шаардах эрхгүй байна.

37.Олимпийн наадмыг зохицуулах хороо - ҮОХ болон ЗБХороо хоорондын ажлын уялдаа холбоо*

1. Олимпийн наадмын зохицуулах хороо:

Олимпийн наадмыг зохион байгуулах ажил, ОУОХ болон Зохион байгуулах хороо, ОУСХ, ҮОХ-дын хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор, тэдгээрийн ажлын уялдаа холбоо, удирдлагыг хангах үүднээс Ерөнхийлөгч Олимпийн наадмын зохицуулах хороог байгуулна. Зохицуулах хороо нь ОУОХ, ОУСХ, ҮОХ-дын болон тамирчдын төлөөлөгчдөөс бүрдэнэ.

2. ҮОХд болон ЗБХ-ны хоорондын ажлын уялдаа холбоо – Тусгай элч /Chef de Mission/

Олимпийн наадмын үеэр тамирчид, албаны хүмүүс, ҮОХ-ны багийн бусад ажилтнууд ҮОХ-ноос томилогдсон тусгай элчийн удирдлага дор ажиллах ба тусгай элч нь ҮОХ-ны өгсөн үүргийг биелүүлэхээс гадна ОУОХ, ОУСХ, ЗБХ-той ажлын уялдаа, холбоотой ажиллах ёстой.

Дүрмийн 37-д хамаарах заалтууд

1. Зохицуулах хорооны эрх үүрэг:

Зохицуулах хороо дараах эрх үүрэгтэй. Үүнд:

1.1 Зохион байгуулах хорооны үйл ажиллагаа, бэлтгэлд хяналт тавих

1.2 Олимпийн наадмыг зохион байгуулахтай холбоо бүхий асуудлыг судлах, хянан нягтлах

1.3 ЗБХ-ны ажилд нь туслах

1.4 ЗБХ болон ОУОХ, ОУСХолбоод, ҮОХороодтой холбоо тогтоож ажиллах

1.5 Эдгээр байгууллагын хооронд үүсч болох аливаа саналын зөрөлдөөнийг арилгах, зохицуулах

- 1.6 ОУОХ-ноос гаргасан Олимпийн наадамтай холбоо бүхий үйл явдлын тухай бүрэн мэдээллийг ЗБХ-гоор дамжуулж ОУСХ-нд болон ҮОХ-дод өгч байх
- 1.7 Олимпийн наадамд хамааралтай аливаа чухал асуудлаар ЗБХ, ОУСХ, ҮОХ-дын гаргаж буй санал бодлын тухай бүрэн мэдээг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд хүргэж байх
- 1.8 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл, ЗБХ-той зөвлөлдсөний үндсэн дээр ҮОХ-дын хамтын ажиллагааг үр ашигтайгаар зохион байгуулах боломжийг судлах, тухайлбал агаарын тээвэрлэлт, ачаа тээвэрлэлтийг зохицуулах, нэмэгдэл албаны хүмүүст байр түрээслэх, ОУСХ, ҮОХд, аялал жуулчлалын байгууллагуудад тасалбар хуваарилах журам зэрэг асуудал энд хамаарна.
- 1.9 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн зөвшөөрлөөр дараах асуудлуудын талаар Зохион байгуулах хороонд санал тавьж шийдвэрлэх.Үүнд:
 - 1.9.1 Уралдаан тэмцээн явагдах болон бэлтгэл сургуулилалт хийх заал танхим Олимпийн тосгонд байрлах байр, төхөөрөмж хэрэгслүүдийг бэлтгэх ажил
 - 1.9.2 Наадамд оролцох, байрлах болон бусад үйлчилгээнд Зохион байгуулах хорооноос гарах зардал
 - 1.9.3 Наадамд оролцогчид, тамирчид, албаны хүмүүсийг тээвэрлэх, байрлуулах, ая тухтай байлгах нөхцөл боломжоор ханган Олимпийн наадмын үеэр тэднийг зайлшгүй шаардагдах чиг үүргээ амжилттай биелүүлэх боломжийг бүрдүүлэх
- 1.10 Уралдаан тэмцээн, бэлтгэл сургуулилалтын байр талбай, бусад байгууламжийг шалган зааварлаж, өөрөө шийдэх боломжгүй аливаа асуудлын талаар ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд илтгэх
- 1.11 ОУСХолбоод болон тусгай элч нарын санал бодлыг ЗБХ нь хүлээн авч арга хэмжээ авч байгаад анхаарал хандуулах
- 1.12 Олимпийн наадмыг зохион байгуулахад тодорхой чиглэлээр ажиллах дагнасан ажлын хэсгүүдийг Гүйцэтгэх Зөвлөлийн зөвшөөрлөөр байгуулах, мөн ажил сайжруулах зорилгоор Зохицуулах хорооноос

хийгдэх арга хэмжээний тухай ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд илтгэж санал, зөвлөлгөө өгөх

1.13 Олимпийн наадам өндөрлөсний дараа уг наадмыг зохион байгуулсан байдалд дүн шинжилгээ хийж ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд илтгэх

1.14 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс өгсөн бусад нэмэлт үүргийг биелүүлэх.

1.15 Зохицуулах хороо шийдэх боломжгүй аливаа асуудал үүсэх, эсвэл аль нэг тал нь түүний шийдвэрийг биелүүлэхгүй явдал гарвал энэ тухай ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд мэдэгдэж, ажилд нь саад учруулж буй бүх нөхцөл байдлыг тодорхойлон илтгэх хэрэгтэй. Энэ тохиолдолд ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл эцсийн шийдвэр гаргана.

1.16 Олимпийн наадмын үеэр Зохицуулах хорооны үүрэг ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд шилжих ба тус хорооны дарга нь ЗБХ-той хийх өдөр тутмын зохицуулах уулзалтад оролцоно.

2. Тусгай элч / Chef de Mission /

Тусгай элч нь Олимпийн наадмын үеэр олимпийн тосгонд байрлаж тэмцээн уралдааны, бэлтгэл сургуулилтын, эмнэлгийн тусламж үзүүлэх байгууламж түүнчлэн хэвлэл мэдээллийн төв, тамирчдын байрлах тосгон зэрэгт нэвтрэх эрхтэй байна.

3. Атташе

ҮОХд нь ЗБХ, ҮОХ-дын хамтын ажиллагааг хөнгөвчлөх, уялдаа холбоогоо сайн байлгахын тулд атташе томилж болно. Атташе нь Зохион байгуулах хороо, өөрийн ҮОХ хоёрын хооронд зуучлагчийн үүрэг гүйцэтгэж тээвэр, байр зэрэг ахуйн бусад асуудлыг шийдвэрлэхэд туслаж ажиллана. Атташе нь Олимпийн наадмын оролцох тухайн улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд орох ётсой.

38. Олимпийн тосгон*

Бүх баг тамирчид, албаны хийгээд бусад төлөөлөгчдийг нэг дор байрлуулахын тулд Зохион байгуулах хороо олимпийн тосгоныг ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс тогтоож өгсөн хугацаанд байгуулж ажиллуулна.

Дүрмийн 38-д хамаарах заалтууд

1. Олимпийн тосгон нь ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс тавьсан бүх шаардлагуудыг хангасан байна.
2. Олимпийн тосгонд байрлуулах албаны хүмүүс, багийн бүрэлдэхүүнд орж байрлах хүмүүсийн тоог ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс тогтооно.
3. ОУОХ нь Олимпийн наадмыг зохион байгуулах хотоос өөр газарт уралдаан тэмцээн явуулах эрхийг ОНЗБХ-нд олгосон үед ОНЗБХ нь ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс тавьсан шаардлагад нийцэх байр, үйлчилгээ, байгууламжаар хангах үүрэгтэй байна.
4. ОНЗБХороо нь Олимпийн тосгонд байрлах бүх тамирчид, албаны хүмүүс, багийн бусад гишүүдийг хүлээж авах, байрлуулах болон тэмцээн уралдаан болох заал танхим, байгууламж болон Олимпийн тосгон хооронд зорчих тээврийн бүх зардлыг хариуцна.

39. Соёлын хөтөлбөр

ОНЗБХ нь олимпийн наадам нээгдсэнээс хойшхи бүх хугацааг хамран явагдах соёлын хөтөлбөрийг зохион байгуулна. Уг хөтөлбөрийн арга хэмжээнүүд нь ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөлд өргөн барьж баталгаажуулна.

II. Олимпийн Наадамд оролцох.

40. Наадамд оролцуулах журам

Олимпийн наадамд оролцохын тулд тамирчид, дасгалжуулагчид, болон багийн бусад бүрэлдхүүн Олимпийн Харт, ОУОХ-ноос баталсан оролцох нөхцөлүүд болон ОУОХ-ноос баталгаажуулсан ОУСХ-дын дүрмийг дагаж мөрдөхийн зэрэгцээ өөрийн ҮОХ-ны мэдүүлэгт орсон байх ёстой.

Наадамд оролцох дээр дурдсан хүмүүс нь:

- шударга өрсөлдөөн, хүч үл хэрэглэх, эв нэгдлийг эрхэмлэнэ.
- Олон улсын сэргээшийн эсрэг дүрмийг баримталж түүнийг бүрэн биелүүлнэ.

Дүрмийн 40-д хамаарах заалтууд

1. ОУСХ-д бүр Олимпийн Хартид нийцүүлэн өөрийн спортын төрлөөр наадамд оролцох шалгуурууд тогтоож ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд өргөн барьж батлуулна.
2. ОУСХолбоод нь өөрсдийн гишүүн үндэсний холбоод болон ҮОХ-д зохих эрх мэдлийнхээ хүрээнд наадамд оролцох шалгууруудаа хэрэглэнэ.
3. ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс зөвшөөрөлгүй бол Олимпийн наадамд оролцогч тамирчин, дасгалжуулагч, албаны хүн уг наадмын үеэр өөрийн бие, овог нэр, зураг, спортын амжилт замналтай холбоотой материалыг реклам сурталчилгааны зорилгоор ашиглуулж болохгүй.
4. Олимпийн наадамд оролцуулах болон тамирчинг мэдүүлэх үйл явц нь санхүүгийн ямар нэгэн бодлогоор хийгдсэн байж болохгүй.

41 Оролцогчдын иргэний харъяалал

1. Олимпийн наадамд оролцогч тамирчин нь өөрийн төлөөлж буй ҮОХ нь харъяалагдах улсын иргэн байна.
2. Олимпийн наадамд оролцогч тухайн тамирчны харъяалалтай холбоотой аливаа маргаантай асуудлыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр шийдвэрлэнэ.

Дүрмийн 41-д хамаарах заалтууд

1. Тухайн тамирчин хоёр болон түүнээс дээш улсын иргэний харъяалалтай байгаа тохиолдолд уг тамирчин өөрөө харьяаллаа сонгоно. Тамирчин нь нэг улсын нэрийн өмнөөс тухайн спортын ОУХ-ноос хүлээн зөвшөөрөгдсөн бүсийн болон дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, мөн бүс нутгийн болон тивийн тоглолт, Олимпийн наадамд оролцсон хэдий ч уг тамирчин нь доор дурдагдах дүрмийн заалтын 2-т тусгагдсан нөхцлүүдийн шаардлагыг

хангатал өөр аль нэг улс буюу шинээр харьяалалаа авсан улсаа төлөөлж тэмцээнд оролцох боломжгүй юм.

2. Олимпийн наадамд тухайн ОУСХ-ноос хүлээн зөвшөөрсөн тив, бүсийн наадам, эсвэл дэлхий, бүсийн аварга шалгаруулах тэмцээнд нэг улсыг төлөөлөн оролцсон тамирчин иргэний харьяаллаа өөрчилсөн, эсвэл шинээр иргэн болсон тохиолдолд харъяатаа сольсны дараах гурван жилийн хугацаанд өөрийн шинэ улсын өмнөөс Олимпийн наадамд оролцож болохгүй. Ийм тохиолдолд тухайн улсын ҮОХ, тухайн спортын ОУХ, ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл хамтран нөхцөл байдлыг зөвшилцөж тохирсоны үндсэн дээр хүлээх ёстой уг гурван жилийн хугацааг багасгах эсвэл бүр хүчингүй болгож болно.
3. Хэрэв зарим улс орны колони, холбооны улс, далайн чанад дахь хэсэг, муж нь тусгаар тогтнолоо зарлах мөн хилийн зурвасын өөрчлөгдсөнөөр нэг нь нөгөөтэйгөө нэгдэх, нэг улс нөгөөдөө дагаар орох зэрэг шалтгаанаар ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн ҮОХ шинээр үүсгэн байгуулагдах тохиолдол байдаг ба энэ тохиолдолд тухайн тамирчин өөрийн хуучин харьяалагддаг улсаа төлөөлж болно. Хэдийгээр уг тамирчин өөрийн сонголтоор шинээр үүсгэн байгуулагдсан ҮОХ-г төлөөлөн Олимпийн тоглолтод оролцож болох ба ингэсэн тохиолдолд энэ сонголтыг зөвхөн нэг удаа л хийх боломжтой.
4. Түүнчлэн тамирчдын харьяалалтай холбоотой бүх асуудалд тухайлбал тухайн тамирчны өөр улсыг төлөөлөн Олимпийн наадамд оролцох эсвэл оролцохоор төлөвлөж байгаа тамирчдын яс үндэс, иргэний харьяалал, байнгын оршин суух газар, хүлээх хугацаа зэрэгт бүх тохиолдолд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нийтлэг эсвэл тухайн байдалд нийцсэн шийдвэр гаргана.

42. Насны хязгаар

Тухайн спортын ОУСХ-ноос гаргаж ОУОХ-ны ГЗ-өөр баталсан тэмцээний дүрэмд тухайлан заагаагүй бол Олимпийн тоглолтод оролцогчдод насны хязгаар тогтоохгүй.

43. Олон улсын сэргээшийн эсрэг дүрэм

Олимпийн хөдөлгөөнд бүхэлд нь Олон улсын сэргээшийн эсрэг дүрмийг заавал мөрдөх ёстой.

44.Урилга ба оролцох мэдүүлэг

1. Олимпийн наадамд оролцох урилгыг нээлтийн ёслол эхлэхээс нэг жилийн өмнө ОУОХ-ноос бүх ҮОХ-дод хүргүүлсэн байна.
2. Олимпийн наадамд оролцох тамирчдын мэдүүлгийг зөвхөн ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн ҮОХ-д танилцуулна.
3. Мэдүүлгийг хүлээн авах эцсийн шийдвэрийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл гаргана. ОУОХ өөрийн үзэмж туршлага дээр үндэслэн аливаа мэдүүлгийг шалтгааныг заахгүйгээр хүлээн авахаас хэзээ ч татгалзаж болно. Татгалзсан тохиолдолд хэн ч Олимпийн наадамд оролцох эрхгүй болно.
4. ҮОХ нь зөвхөн үндэсний спортын холбооны санал болгож оруулсан тамирчдын мэдүүлгийг явуулна. ҮОХ нь мэдүүлгийг баталгаажуулж байж ОНЗБХ-нд илгээнэ. ОНЗБХ нь үүнийг хүлээн авснаа заавал эргэж мэдэгдэнэ. ҮОХ нь үндэсний спортын холбооноос санал болгосон мэдүүлэг нь хэн нэгнийг арьсны өнгө, шашин шүтлэг, улс төрийн шалтгаан болон бусад хэлбэрээр ялгаварлан гадуурхаагүй гэдэгийг нягтлан шалгах үүрэгтэй.
5. ҮОХ нь олон улсын тэмцээн уралдаанд өндөр хэмжээнд бэлтгэж шаардлага хангасан тамирчдыг Олимпийн наадамд илгээнэ. Үндэсний спортын холбоод нь өөрсдийн харъяалагдах ОУСХ-оор дамжуулан тухайн ҮОХ-ноос гаргасан мэдүүлэг, шийдвэртэй холбоотой асуудлын талаар ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд хүсэлтээ гаргаж болно. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь эцсийн шийдвэрийг гаргана.

Дүрмийн 44-д хамаарах заалтууд

1. Олимпийн наадамд оролцох бүх оролцогчдын тоог ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс тогтооно.

2. Олимпийн наадмын спортын уралдаан тэмцээнд оролцогчдын мэдүүлгийг өгөх, түүнийг хүлээн авах журам, хугацааг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс зааж өгнө.
3. Бүх мэдүүлгийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр батлагдсан тусгай маягтын дагуу бөглөж явуулна.
4. Олимпийн наадамд оролцох урьдчилсан гол болзол нь тамирчин бүр Олимпийн хартийн бүх заалтыг даган мөрдөж, өөрсдийн харъяалагдах ОУСХ-ноос гаргасан дүрэм журамд захирагдах ёстой. Тамирчнаа Олимпийн наадамд оролцуулж байгаа ҮОХ нь тухайн тамирчиддаа Олимпийн хартын заалтууд болон Олон Улсын Сэргээшийн эсрэг дүрмийг танилцуулж түүнийг мөрдүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.
5. Хэрвээ тухайн спортын төрлөөр улс оронд нь үндэсний холбоо байхгүй, харин ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн ҮОХ байх тохиолдолд тухайн төрлөөр Олимпийн наадамд оролцох тамирчинг ОУОХ, ОУСХ-ны зөвшөөрлийн үндсэн дээр бие дааж оруулахаар мэдүүлж болно.
6. Олимпийн наадамд оролцогчид бүгд ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс гаргасан мэдүүлгийн маягтыг бүрэн гүйцэд бөглөсөн байх шаардлагатай.
7. Дээрхи 6-р зүйлд заасанчлан аливаа орны ҮОХ нь өөрийн улсынхаа спортын үндэсний холбоог төлөөлж Олимпийн наадамд оролцогчдынхоо мэдүүлгийн маягтыг зүй ёсны дагуу бөглөсөн эсэхийг баталгаажуулж оролцогчдод танилцуулах ба энэ нь мөн холбогдох ОУСХ-гоор давхар баталгаажсан байна.
8. Дээр дурдсан нөхцөлүүдийг хангаагүй бол мэдүүлгийг хүчин төгөлдөр гэж тооцохгүй.
9. Олимпийн наадамд оролцох төлөөлөгчдийн бүрэлдхүүнд албан ёсоор багтсан баг, тамирчдыг ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлийн зөвшөөрөл авалгүй Олимпийн хартын заалтыг зөрчиж оролцох эрхийг нь цуцласан байвал уг шалтгааныг олж тогтоох цаашилбал оролцох эрхүүдийг хорих хүртэл арга хэмжээ авна.

10. ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл нь спортын төрөл бүрт Олимпийн наадамд оролцох тамирчдын тоог тогтоохдоо холбогдох ОУСХ-ноос Олимпийн наадам болохоос 3 жилийн өмнө хүргүүлсэн зөвлөмжийг баримтална.
11. Хувийн төрлөөр өрсөлддөг спортын хувьд оролцогчдын тоо нь Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд зөвшөөрөгддөг тооноос хэтрэхгүй байх ба нэг төрөлд нэг улсаас гурваас илүү тамирчин оролцохгүй байх ёстой. ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс өвлийн спортын зарим төрөлд жичид нь зөвшөөрөл олгож болно.
12. Багийн спортын хувьд ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс өөрөөр заагаагүй бол багийн тоо нь хүйс тус бүрд арван хоёроос хэтрэхгүй, наймаас цөөнгүй байна.
13. Зарим спортын ганцаарчилсан болон багийн төрөлд орлон тоглогчдын тоог адил тэнцүү байлгах бодлого барьж, зарим спортын төрөлд орлон тоглогчгүй оролцуулж болох ба тухайн спортын ОУСХ-ны зөвлөсний дагуу ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс орлон тоглогчдын тоог нэмэх эсвэл хасан тогтоож болно.
14. ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл нь Олимпийн наадмыг зохион байгуулагч хоттой тохиролцож гарын үсэг зурсан гэрээний дагуу Олимпийн наадамд оролцох тамирчдын тоог арван мянга таван зуу /10500/, харин албаны төлөөлөгчдийн тоог таван мянга /5000/-аас хэтрүүлэхгүй.

III. ОЛИМПИЙН НААДМЫН ХӨТӨЛБӨРҮҮД

45. Олимпийн тоглолтын хөтөлбөрүүд

1. Олимпийн наадмын хөтөлбөр)цаашид “хөтөлбөр” гэх(гэдэг нь одоо хүчинтэй мөрдөгдөж байгаа дүрэм журамд нийцүүлэн ОУОХ-ноос тухайн Олимпийн наадмын бүх уралдаан тэмцээнүүдэд зориулан гарсан цогц хөтөлбөр юм.
2. Олимпийн наадмын хөтөлбөрт олон төрөлт, нэг төрлийн болон бусад спортын уралдаан тэмцээнүүд багтана. Спортын төрлүүдэд дүрмийн 45.1

болон 45.2-д тусгагдсан ОУСХ-дын эрхлэн явуулдаг, удирддаг спортын төрлүүд багтана. Олон төрөлт гэдэг нь нэг болон хэд хэдэн төрлөөс бүрдэх спортын төрлийг хэлнэ. Нэг төрөлт гэдэг нь спортын зөвхөн нэг төрлөөр эсвэл олон төрөлтийн нэг төрөлд өрсөлдөн чансаагаа тогтоолгон шагнал, медаль авдаг тэмцээн уралдааныг хэлнэ.

3. Хөтөлбөрт спортын төрлүүдээс сонголт хийх мөн түүнчлэн аливаа спортын төрлийг хөтөлбөрт багтаах шалгуур, нөхцлийг тодорхойлох нь Чуулганы бүрэн эрхэд хамаарна. Зөвхөн сэргээшийн эсрэг олон улсын дүрмийг дэмжигч спортын төрлүүдийг хөтөлбөрт багтаах эсвэл хэвээр үлдээнэ.
4. Хөтөлбөрт аливаа нэг төрлийн болон олон төрөлт спортын төрлүүдийг багтаах шийдвэр нь ОУОХ-ны Гүйцэтгэх завлөлийн эрхэд хамаарна.

Дүрмийн 45-д хамаарах заалтууд

1. Олимпийн наадамд мөрдөгдөх ерөнхий заалтууд
 - 1.1 Олимпийн наадмын аливаа арга хэмжээний дараа ОУОХ хөтөлбөрийг дахин хянаж үзнэ. Ингэхдээ тухайн спортын төрөл, уралдаан тэмцээний стандарт, ОУОХ-ны эрх бүхий байгууллагаас тогтоосон спортын уралдаан тэмцээний төрлийг багтаах, эс багтаах эсэхийг дахин хянаж болно.
 - 1.2 Олимпийн наадмын аливаа хөтөлбөрийг бэлтгэн гаргах талаар Чуулганаас ямар нэгэн шийдвэр гаргахаас өмнө хөтөлбөрт багтаахаар санал оруулсан тухайн спортын ОУСХ нь тухайн Олимпийн наадмын хөтөлбөрт оролцох тухайгаа баталж ОУОХ-нд мэдэгдэнэ.
 - 1.3 Олимпийн наадмын хөтөлбөрт ямар нэг спортын төрлийг багтаах нь Олимпийн наадмын зохион байгуулах хотыг Чуулганаар сонгон шалгаруулах хугацаанаас хэтрэлгүйгээр шийдвэрлэгдэнэ.
 - 1.4 Олимпийн наадмын хөтөлбөрт багтаах спортын төрөл уралдаан тэмцээнийг Олимпийн наадам эхлэхээс 3 жилийн өмнө ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс шийдвэрлүүлнэ.

- 1.5 Тухайн спортын ОУСХ, ОНЗБХ, ОУОХ-ны эрх бүхий байгууллага нь хөтөлбөрт өөрчлөлт оруулахаар зөвшөөрсөн тохиолдолд дүрмийн 45.1.3 ба 1.4-д зүйлд товолж заасан хугацааг өөрчилж мөн хүчингүй болгож болно.
- 1.6 Хөтөлбөрт ямар нэгэн спортыг багтаах шийдвэр гаргахаас өмнө Чуулган багтахын тулд тавигдах тодорхой шалгуур нөхцлийг боловсруулна.
- 1.7 Аливаа спортын ОУХ нь Олимпийн харт, сэргээшийн эсрэг олон улсын дүрмийг дагаж мөрдөхгүй байгаа тохиолдолд Чуулган тухайн спортын төрлийг ямар ч үед Олимпийн хөтөлбөрөөс хасах эрхтэй байна.
- 1.8 Хэрэв тухайн спортын ОУСХ нь Олимпийн харт болон сэргээшийн эсрэг олон улсын дүрмийг дагаж мөрдөхгүй байгаа тодорхой, ноцтой үндэслэл байвал дүрмийн 45.2.1.2 болон 3.1.2-т заасанчлан ОУСХ-дын тоог бууруулж болох журамыг баримтлан тухайн ОУСХ-г жагсаалтаас хасах саналыг Чуулганд оруулж шийдүүлж болно.
- 1.9 ОУСХ-дтой хамааралтай аливаа санал нь Чуулганаар орж шийдвэр гарахаас өмнө дүрмийн 45.1.1.7 болон 1.1.8-д заасны дагуу гарах шийдвэртэй холбоотой асуудлын талаар тухайн ОУСХ-ноос тайлбар сонсож болно.

2. Олимпийн наадамд мөрдөгдөх заалтууд

2.1 Хөтөлбөрт багтсан спортын төрлүүд

2.1.1 Хөтөлбөрт багтсан спортын төрлүүд нь үндсэн (хойшид үндсэн төрлүүд гэх) болон нэмэлт төрлүүдээс бүрдэнэ.

2.1.2 Үндсэн спортын төрлүүдэд ОУОХ-ноос санал болгосны дагуу Чуулганаар сонгосон дараахь ОУСХ-дын удирдлага доор үйл ажиллагаа нь явагддаг спортын доод тал нь 25 төрөл орно.

- Олон улсын хөнгөн атлетикийн холбоо (IAAF)

- Олон улсын сэлүүрт завины холбоо (FISA)

- Олон улсын бадминтоны холбоо (BWF)

-Олон улсын сагсан бөмбөгийн холбоо (FIBA)

-Олон улсын боксын холбоо (AIBA)

-Олон улсын каное завины холбоо (ICF)

-Олон улсын дугуйн холбоо (UCI)

- Олон улсын морин спортын холбоо (FEI)
- Олон улсын туялзуур жадны холбоо (FIE)
- Олон улсын хөлбөмбөгийн холбоо (FIFA)
- Олон улсын гимнастикийн холбоо (FIG)
- Олон улсын хүндийг өргөлтийн холбоо (IWF)
- Олон улсын гандболын холбоо (IHF)
- Олон улсын хоккейн холбоо (FIH)
- Олон улсын жүдо бөхийн холбоо (IJF)
- Олон улсын бөхийн төрлүүдийн холбоо (FILA)
- Олон улсын усанд сэлэлтийн холбоо (FINA)
- Олон улсын орчин үеийн 5 төрөлтийн холбоо (UIPM)
- Олон улсын таеквондогийн холбоо (WTF)
- Олон улсын теннисний холбоо (ITF)
- Олон улсын ширээний теннисний холбоо (ITTF)
- Олон улсын буудлага спортын холбоо (ISSF)
- Олон улсын байт сурын холбоо (WA)
- Олон улсын триатлоны холбоо (ITU)
- Олон улсын дарвуулт завины холбоо (ISAF)
- Олон улсын волейболын спортын холбоо (FIVB).

2.1.3 Чуулган үндсэн спортын төрлөөр сонгоогүй гэхдээ ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн ОУСХ-дийн спортын төрлүүд болон дүрмийн 45.2.1.2-т тусгагдсан спортын төрлүүдээс ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн санал болгосноор Чуулган нэг буюу хэд хэдийг спортын төрлийг нэмж сонгож болно.

2.1.4 Чуулганаар сонгон хөтөлбөрт оруулсан нэмэлт спортын төрлийн тоон дээр үндсэн спортын төрлүүдийг хамтатган хөтөлбөрт багтсан спортын нийт тоог бүрдүүлэх ба энэ нь 28-аас хэтрэхгүй байна.

2.2 Хүчин төгөлдөр мөрдөгдөх журам

2.2.1 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь үндсэн спортын төрлийг бүрдүүлдэг дор хаяж 25 спортын төрлийг хөтөлбөрт багтаахаар Чуулганд санал орлуулна. Чуулган үндсэн спортод бүгдийг багтаах эсэхэд багцлан санал өгч, шийдвэр олонхийн саналаар шийдвэрлэгдэнэ. Хэрэв олонхийн санал бүрдээгүй бол Ерөнхийлөгчийн удирдлага дор дахин санал хураалт явуулна. Дахин санал хураалтаар хөтөлбөрт багтсан бүх спортууд үндсэн спортын төрлийг бүрэлдүүлнэ.

2.2.1 Дүрмийн 45.2.2.1–д нийцүүлэн үндсэн спортын жагсаалтыг

бүрэлдүүлсэн бол ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл дүрмийн заалт 45.2.1.3.-д заасанчлан нэг буюу хэд хэдэн спортыг нэмэлт спортын төрөлд багтаахаар Чуулганд саналаа өгч болно. Чуулган нэмэлт спортын төрлүүдийг хөтөлбөрт оруулахаар багцалж эсвэл ганцаарчилсан хэлбэрээр санал өгч, шийдвэр олонхийн саналаар шийдвэрлэгдэнэ.

3. Өвлийн олимпийн наадамд мөрдөгдөх заалтууд

3.1 Хөтөлбөрт спортын төрлийг багтаах нь

3.1.1 Хөтөлбөрт багтсан спортууд үндсэн спортын төрлүүдийг бүрдүүлнэ. (цаашид "үндсэн төрлүүд" гэнэ).

3.1.2 Дараах олон улсын холбоодын спортыг үндсэн төрөлд багтаана:

- Олон улсын биатлоны холбоо (IBU);
- Олон улсын чарганы спортын холбоо (FIBT);
- Олон улсын керлингийн холбоо (WCF);
- Олон улсын шайбтай хоккейн холбоо (IIHF);
- Олон улсын Luge холбоо (FIL);
- Олон улсын тэшүүрийн холбоо (ISU);
- Олон улсын цанын холбоо (FIS).

3.1.3 Хүчин төгөлдөр мөрдөгдөх журам

Чуулган үндсэн спортод бүгдийг багтаах эсэхэд багцлан санал өгч, шийдвэр олонхийн саналаар шийдвэрлэгдэнэ. Хэрэв олонхийн санал бүрдээгүй бол Ерөнхийлөгчийн удирдлага дор Чуулганаар дахин санал хураалт явуулна. Дахин санал хураалтаар хөтөлбөрт багтсан бүх спортууд үндсэн спортын төрлийг бүрэлдүүлнэ.

3.1.4 Нэмэлт спортуудыг хөтөлбөрт багтаахад мөрдөх дүрэм журам нь Олимпийн наадамд мөрдөх бусад дүрэм журамтай адил байна.

46. Олимпийн наадамд ОУСХ-дод ноогдох мэргэжил, техникийн хариуцлага*

1. Аливаа спортын ОУХ нь олимпийн наадмын үеэр өөрийн спортын уралдаан тэмцээнийг техникийн хяналт, удирлагаар хангах үүрэг хүлээнэ. Мөн тэмцээний төлөвлөгөө, тоглох талбай, бэлтгэлийн талбай, бүх тоног төхөөрөмж зэрэг тэмцээний бүх элементүүдийг өөрийн дүрэмд нийцүүлэхийг шаардана. Эдгээр бүх техникийн бэлтгэлийн хувьд ЗБХ нь тухайн ОУХ-дтой зөвшилцөнө. Спортын төрөл тус бүрийн бүх тэмцээнийг зохион байгуулах ажлыг тухайн спортын ОУХ шууд хариуцна.
2. ЗБХ нь олимпийн наадмын хөтөлбөрт багтсан спортын бүх төрөлд эн тэнцүү хандаж, тэдгээрийг нэгдмэл гэдгийг батлах ёстой.
3. Тэмцээний төлөвлөгөө, тэмцээний өдөр тутмын цагийн хуваарийн хувьд эцсийн шийдвэрийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл гаргана.
4. ОУСХ-дтой нэг бүрчлэн зөвлөлдсөний эцэст ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл сэргээшийн шинжилгээнд тамирчдыг түүвэрлэн сонгох тоог тодорхойлж, түүвэр сонголтийг хийнэ. Мөн олимпийн наадмын үеэр сэргээшийн эсрэг бусад арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Дүрмийн 46-д хамаарах заалтууд

1. Олимпийн наадмын техникийн бэлтгэл:

Спортын Олон Улсын Холбоод нь Олимпийн наадмын техникийн бэлтгэлийг хангахтай холбоотойгоор дараахь эрх эдэлж үүрэг хүлээнэ:

- 1.1 Хариуцаж буй спортынхоо төрөл, үр дүнгийн стандарт, тоног төхөөрөмж, спортын байгууламжийн техникийн онцлог, хөдөлгөөн, дасгал, тоглолтын техникийн дүрэм, эрх хасах дүрэм, шүүлтийн болон завсарлага авах дүрэм зэргийг боловсруулна.
- 1.2 Олимпийн тэмцээн уралдааны эцсийн үр дүн, чансаа эрэмбийг тогтооно. Зохион байгуулах хороо нь спортын уралдаан тэмцээн бүрийн дараа

тэмцээний дүнг ОУОХорооноос баталсан дүрэм, журамд нийцүүлэн спортын ОУХолбоодод, өөрийн зардлаар, цахим хэлбэрээр нэн даруй хүргүүлнэ. Тухайн спортын Олон улсын холбоо нь тухайн тэмцээний дүнг өөрийн албан ёсны цахим хуудсанд тавих эрхтэй.

1.3 ОУОХ-ны эрх мэдлийн хүрээнд олимпийн наадмын тэмцээн, бэлтгэлийн үед тухайн спортын тэмцээн, бэлтгэлийн заал танхимд ажиллах техникийн ажилчдыг дадлагажуулах ёстой.

1.4 Тухайн спортын ОУХ-ны санал болгосоноор ОУОХ-ноос баталсан тоонд багтаан зохион байгуулагч болон бусад улс орноос шүүгч, техникийн бусад ажилтнуудыг сонгож авна. Зохион байгуулагч орноос бусад орноос ирсэн шүүгчид, техникийн бусад ажилтнуудын байр, унаа, дүрэмт хувцасны зардлыг Зохион байгуулах хорооноос гаргана. Шүүгчид, техникийн ажилтнууд тухайн спортын эхний тэмцээн уралдаанаас дор хаяж 3 хоногийн өмнө, сүүлчийн тэмцээн уралдаанаас 1 хоногийн дараа тэмцээн явагдсан газар байх ёстой.

1.5 Баталсан дүрэм журмыг мөрдөхийн тулд тухайн спортын байгууламжийг төлөвлөх, барьж байгуулах явцад техникийн 2 төлөөлөгчийг томилно. Тамирчдын бүртгэл, тэмцээний заал танхимын стандарт, тэмцээний цагийн хуваарь, олимпийн наадмын өмнөх арга хэмжээ, мөн түүнчлэн техникийн ажилтнууд, шүүгчдийн байр, хоол, унааны нөхцөл зэрэг тэмцээн уралдааны техникийн элементүүдийг хянаж батлана.

1.5.1 Тухайн спортын ОУХ-ноос томилогдсон техникийн 2 төлөөлөгч нь уг спортын эхний тэмцээн уралдаан эхлэхээс дор хаяж 5 хоногийн өмнө бүртгэлтэй холбоотой шаардлагатай бүх бэлтгэлийг хангуулахын тулд тэмцээн уралдааны байранд ирж ажиллана.

1.5.2 Тухайн хугацаанд болон Олимпийн наадам болтол уг төлөөлөгчидтэй холбоотой гарах зардал (2500 км-ээс дээших аяллын зардлыг бизнес ангиллаар, 2500 км хүртэлх аяллын зардлыг энгийн ангиллаар тооцож, тосч авах, хүргэж өгөх)-ыг Зохион байгуулах хорооноос хариуцна.

1.5.3 Онцгой тохиолдолд техникийн шаардлагын үүднээс төлөөлөгчдийн оролцох нэмэлт айлчлалыг шаардлагатай гэж үзвэл Зохион байгуулах хороо нь Олон улсын олимпийн хороонд мэдэгдсэний дараа зохих бэлтгэлийг хангана. Санал зөрөлдөх тохиолдолд Олон улсын олимпийн хорооны Гүйцэтгэх зөвлөл шийдвэрлэнэ.

1.6 Бүх тамирчид Дүрмийн 40-50 дахь заалтыг дагаж мөрдөхөө батална.

1.7 ОУОХ болон ҮОХ-дын эрх, оролцогчдын олимпийн наадам эхлэхээс өмнөх ба олимпийн наадмын үеэрх эрхтэй холбоотой ОУОХ-ны дүрмийг мөрдүүлэх

1.8 Нэр дэвшигч хотод тухайн спортын Олон улсын холбооны зүгээс тавих техникийн шаардлагыг ОУОХ-той хамтран боловсруулах, шинэчилэн найруулах

2. Техникийн нөхцлийг ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөр батлуулахаар өргөн барихаас өмнө тухайн спортын Олон улсын холбоод, ЗБХороогоор зөвшөөрүүлнэ:

2.1 Тухайн Олимпийн наадам болохоос 2 жилээс багагүй хугацааны өмнө спортын хөтөлбөрийн өдөр тутмын цагийн хуваарийг батлуулна.

2.2 Олимпийн наадмын заал танхимаас гадна болж байгаа арга хэмжээний явах зам чиглэлийг тогтоох (Дарвуулт завь, марафон гүйлт, спорт алхаа, дугуйн уралдаан, морин спортын тэмцээн гэх мэт)

2.3 Олимпийн наадмын өмнө болон наадмын үеэр бэлтгэл хийх заал танхим байгууламжид тавигдах шаардлага.

2.4 ОУСХ-дын дүрэмд тусгагдаагүй заал танхимд тавигдах техникийн шаардлага.

2.5 Тэмцээн уралдааны дүнг танилцуулах техник тоног төхөөрөмж.

2.6 Олимпийн наадмын үеэр спортын ОУХ-дын албаны хүмүүс (шүүгч зэрэг)-ийн өмсөх дүрэмт хувцас.

3. ОУСХ-ноос ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд батлуулахаар оруулах шаардлагатай санал:

3.1 Тухайн спортын Олимпийн наадмын хөтөлбөр, спортын төрөл буюу спортын уралдаан тэмцээнийг уг хөтөлбөрт оруулах эсвэл хасах.

3.2 Уралдаан тэмцээнд оролцох тамирчдын тоог тэмцээн тус бүрээр, орон орноор, мөн Олимпийн наадамд оролцох багийн тоог тогтооно.

3.3 Олимпийн наадам болохоос өмнө 2 жилээс хэтрэхгүй хугацаанд Олимпод орох эрх авах сонгон шалгаруулалтын тогтолцоог боловсронгуй болгоно.

3.4 Олимпийн наадамд оролцох тамирчид болон багуудын урьдчилсан шатны шалгаруулалтын оноолтыг бэлэн болгох .

3.5 Ганцаарчилсан болон багийн спорт, уралдаан тэмцээний орлон тоглогчийн тоог тогтоох

3.6 Олимпийн наадмын бэлтгэл ажлыг шалгах, нэмэлт айлчлалыг зохион байгуулахад Олимпийн хартид тусгасанаас бусад тохиолдолд 2-оос дээш техникийн төлөөлөгч оролцох эсэхийг шийдэх.

3.7 ОУСХ нь олимпийн тэмцээн уралдааны дуу, дүрсний бичлэгийг үйлдвэрлэж, арилжааны зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж, ашиглахыг хориглоно.

4. Техникийн бэлтгэл ажилтай холбоотой нэмэлт нөхцлүүд:

4.1 Олимпийн наадам эхлэхээс 3 жилийн өмнөөс ОУСХ-д нь Олимпийн наадмын үеэр заал танхимыг тоноглоход хэрэглэх техникийн болон спортын тоног төхөөрөмжийн үзүүлэлтийн талаар Зохион байгуулах хороо, ОУОХ, ҮОХ-дод мэдэгдэнэ. Тухайн спортын ОУХ нь ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс гаргасан зааварчилгааг спортын тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлд дагаж мөрдөхийг тухайн үйлдвэрлэгч компаниудаас шаардах эрхтэй.

4.2 Спорт тус бүрийн зайлшгүй шаардлагатай техникийн ажилтнууд (шүүгч, цаг хянагч, шалгагч) болон давж заалдах шүүгчдийн бүрэлдэхүүнийг тухайн спортын холбоодын зөвлөсний дагуу ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс баталсан нийт тооны хязгаарт багтаан ОУСХ-д томилно. Томилогдсон хүмүүс тухайн спортын ОУХ-дын удирдлага, ЗБХ-ны зохицуулалт дор өөрт ноогдсон үүргээ гүйцэтгэнэ.

4.3 Шийдвэр гаргахад оролцсон албаны ажилтан нь онооны маргааныг шийдвэрлэх үүрэгтэй шүүгчдийн бүрэлдэхүүнд гишүүнээр орохгүй.

4.4 Шүүгчдийн бүрэлдэхүүний гаргасан шийдвэрийг ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлд аль болох хурдан мэдэгдэнэ.

4.5 Тухайн спорттой холбоотой техникийн бүх асуудлыг шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн, холбогдох торгууль шийтгэл зэрэг шүүх бүрэлдэхүүний гаргасан шийдвэрийг тус тус давж заалдахгүй, хохирол учруулахгүйгээр авах нэмэлт арга хэмжээ, шийтгэлийг ОУОХорооны Гүйцэтгэх зөвлөл болон Чуулганаар шийдвэрлэнэ.

4.6 Зохион байгуулах хороо нь ОУСХ-доос томилогдсон бүх техникийн ажилтнуудын байрлах байрыг олимпийн тосгоноос тусад нь байгуулах ба шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана. Техникийн ажилтнууд болон шүүгчдийн бүрэлдэхүүний гишүүдийг олимпийн тосгонд байрлуулахыг хориглоно. Тэднийг УОХ-ны төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд хамааруулдаггүй. Харин тухайн олон улсын спортын холбооддоо хамаарна.

5. ОУСХ-дын байр, тоног төхөөрөмж:

5.1 Олимпийн наадмын үед ЗБХ нь уг наадмын хөтөлбөрт орсон спортын ОУ-ын холбоог өөрийн зардлаар техник, технологийн хэрэгсэл, шаардлагатай байр, тоног төхөөрөмжөөр хангана.

5.2 ЗБХ нь дээр дурдсан ОУСХ-дыг тэдгээрийн хүсэлтээр шаардлагатай

удирдлагын байр, техник тоног төхөөрөмж, мөн түүнчлэн зочид буудал, хэрэв боломжтой бол зохион байгуулах хотод хуралдаан хийх боломж бүрдүүлэх зэрэг асуудлыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр батлуулахаар оруулна.

6. Спортын холбоодоос тамирчдыг сонгон шалгаруулах нь:

6.1 Тамирчдад Олимпийн эрх олгох сонгон шалгаруулалтын тогтолцоог батлуулахаар олон улсын спортын холбоодоос ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд өргөн барина. ҮОХ нь тамирчдыг сонгон шалгаруулах уг тогтолцооны талаар мэдээллийг ОУОХ-ноос авна.

6.2 Зарим спортын хувьд ОУСХ-д олимпийн наадамд оролцох тамирчид, тухайлбал багийн спортод багуудыг сонгон шалгаруулахын тулд сонгон шалгаруулах тэмцээн зохион байгуулж, хязгаарлагдмал тооны оролцогчдыг хамруулж болно.

6.3 Дүрэм 48, 55, 56 нь тамирчдыг сонгон шалгаруулах тэмцээнд хамаарахгүй.

7. ЗБХ-оос зохион байгуулах Олимпийн өмнөх тэмцээн:

7.1 ЗБХ нь ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд батлуулахаар өргөн барьсан журмын дагуу, ОУСХ-дын зөвлөсний дагуу олимпийн наадмын үеэр хэрэглэгдэх тоног төхөөрөмжүүд, ялангуяа заал талбайн техникийн байдал, технологийг шалгах зорилгоор олимпийн өмнөх сорил тэмцээнүүдийг зохион байгуулж болно.

7.2 Олимпийн өмнөх тэмцээн тухайн спортын ОУХ-дын техникийн хяналт дор явагдах ёстой.

7.3 Олимпийн өмнөх тэмцээнд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн тогтоосон

хэмжээгээр олимпийн хартийн заалтуудыг дагаж мөрдөнө.

47. Залуучуудын зуслан

ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс олгосон эрх мэдлийн хүрээнд ЗБХороо нь хүлээсэн үүргийн дор олимпийн наадмын үеэр олон улсын залуучуудын зусланг байгуулж болно.

48. Олимпийн наадмыг зурагт, хэвлэл мэдээлэлээр сурталчлах нь*

1. ОУОХ нь олимпийн наадмыг төрөл бүрийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр аль болох өргөн олон нийтийг хамруулсан үзэгчдэд дэлхий дахинаа хүргэх үүднээс шаардлагатай бүх арга хэмжээг авна.

2. Мэдээллийн хэрэгслээр олимпийн тоглолтыг дамжуулах тухай бүх шийдвэрийг ОУОХ эрхийнхээ хүрээнд гаргана.

Дүрмийн 48-д хамаарах заалтууд

1. Олимпийн наадмыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах нь Олимпизмын зарчим, үнэт зүйлсийг дэлгэрүүлж, хөхүүлэн дэмжих явдал гэсэн утгаараа Олимпийн хөдөлгөөний зорилго юм.

2. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь олимпийн наадмыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах техникийн бүхий л дүрэм журам, тавигдах шаардлагыг зохион байгуулах хоттой байгуулах гэрээний салшгүй хэсэг болох хэвлэл мэдээллийн хэрэгслийн техникийн удирдамжид боловсруулан зааж өгнө. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн техникийн удирдамж, ОУОХ-ны ГЗ-өөс боловсруулсан бусад бүх зааврын агуулга нь олимпийн наадмыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулахад оролцогч бүх хүмүүст хамаарна.

3. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэгэн адил зөвхөн магадлан итгэмжлэгдсэн хүмүүс сэтгүүлч, сурвалжлагч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтаны үүрэг гүйцэтгэнэ. Олимпын наадмын үеэр ямар ч тохиолдолд тамирчин, шүүгч, албаны хүн, хэвлэлийн атташе, бусад итгэмжлэгдсэн оролцогч хэн ч байсан гэсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн бусад ажилтаны үүрэг гүйцэтгэж үл болно

49. Олимпын наадмыг хэвлэлээр нийтлэх нь*

Олимпын наадамтай холбоотой болон, ОУОХ-нд шаардлагатай хэвлэлтийг ЗБХ-ны зардлаар ОУОХ-ны хүссэн форматаар хэвлэж, тараана.

Дүрмийн 49-д хамаарах заалтууд

1. Зохион байгуулах хороо нь дараах хэвлэл, бичиг баримтийг бэлдэх, үйлдвэрлэх, хэвлэх, ОУОХ, ОУХ, ҮОХороодод бүгдэд нь тараах үүрэг хүлээнэ:

1.1 Спортын төрөл тус бүрээр ерөнхий хөтөлбөр, техникийн бэлтгэлийн талаар тайлбар танилцуулга

1.2 ОУОХ-ны зааврын дагуу эмнэлэг үйлчилгээний танилцуулга

1.3 ОУОХ-ны удирдлага дор олимпын наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх, зохион байгуулах тухай бүрэн хэмжээний тайлан.

2. Олимпын наадамтай холбоотой бичиг баримт, хэвлэлийн хувьд ЗБХ нь ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн зааврыг мөрдлөгө болгоно. Ерөнхий дүрмийг баримтлан бичиг баримт, хэвлэлийн агуулгыг урьдчилан батлуулахаар ОУОХ-нд өргөн мэдүүлнэ.

50. Зар сурталчилгаа, суртал ухуулга*

1. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь зар сурталчилгааны аливаа төрөл, өөр бусад хэвлэл нийтлэлд зөвшөөрөл олгох зарчим, нөхцөлийг боловсруулна.

2. Цэнгэлдэх хүрээлэн, заал танхим, олимпийн талбар гэж үзсэн өөр бусад газруудын дотор, дээр ямар нэг хэлбэрээр сурталчилгаа явуулах, хэвлэн нийтлэхийг эс зөвшөөрнө. Арилжааны зориулалттай тоног төрөөрөмж, зар сурталчилгааны самбарыг цэнгэлдэх хүрээлэн, заал танхим, спортын бусад газруудад байрлуулахыг эс зөвшөөрнө.

3. Жагсаал, улс төр, шашин, арьс өнгөөр ялгаварлах суртал нэвтрүүлгийг олимпийн талбай, заал танхим, бусад газруудад хийхийг хориглоно.

Дүрмийн 50-д хамаарах заалтууд

1. Дараах 8 зүйл - таниулга буюу тухайн эд болон тоног төхөөрмжийн үйлдвэрлэгчийг таниулахаас бусад тохиолдолд бусдын бие, спортын хувцас, хэрэглэл, ерөнхийдөө олимпийн наадамд оролцож байгаа тамирчид болон бусад оролцогчдын өмссөн хувцас эсвэл хэрэглэж байгаа тоног төхөөрөмж дээр хэвлэн нийтлэх, суртал нэвтрүүлэг явуулах, арилжаа наймаа хийх, өөр бусад хэлбэрийг зар сурталчилгааны зориулалтаар олны анхаарал татсан гэж үзнэ.

1.1 Үйлдвэрлэгчийг хувцас, хэрэглэлээс өөр бусдаар таниулахгүй.

1.2 Тоног төхөөрөмж: Үйлдвэрлэгчийн таниулга тэмцээний үеэр тухайн тоног төхөөрмжийн ил гарах талбайн 10%-иас хэтэрсэн байвал олон нийтийн анхаарал татсан байна гэж үзнэ. Ингэхдээ 60 см²-аас хэтрэхгүй байна.

1.3 Малгай (малгай, дуулга, нарны ба усны шил) бээлий: Үйлдвэрлэгчийн шошго 6 см² -иас хэтэрсэн байвал олон нийтийн анхаарал татсан байна гэж үзнэ.

1.4 Хувцас (Футболк, шорт, бэлтгэлийн өмд цамц): Үйлдвэрлэгчийн шошго 20 см² -иас хэтэрсэн байвал олон нийтийн анхаарал татсан байна гэж үзнэ.

1.5 Гутал: Үйлдвэрлэгчийг бусдаас ялгах шошго тэмдэг нь харагдахуйц

байхыг зөвшөөрөх бөгөөд хэмжээ нь жижиг томоороо 6 см-с хэтрэхгүй байна.

1.6 Дээр дурдсан дүрмээс гадуур тухайн спортын олон улсын холбоодоос тусгайлан батлан хэрэглэх тохиолдолд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс зөвшөөрөл авна.

Дээрхи дүрмийн заалтуудыг зөрчсөн тохиолдолд тэмцээн уралдаанаас хасах, эрхийг хураах хүртэл арга хэмжээ авна. Энэ тохиолдолд ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл эцсийн шийдвэрийг гаргана. Тамирчдын арын номерт Олимпийн наадмыг зохион байгуулах хорооны эмблемийг байрлуулах ёстой.

2. ЗБХ-ны бүтээсэн олимпийн наадмын эмблем, бэлгэ тэмдгийг хэрэглэх эрх, зөвшөөрөл олгосон зар сурталчилгааны аливаа зүйл бүхий гэрээ нь Олимпийн харти, ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргасан удирдамжид нийцэж байж хүчин төгөлдөр болно. Цаг тоолох тоног төхөрөмж, онооны самбар, телевизийн хөтөлбөрөөр таних тэмдэг оруулах зэрэгт дээрхийн адил байна. Эдгээр зохицуулалтыг зөрчвөл ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн эрхийн хүрээнд асуудлыг авч хэлэлцэнэ.

3. Олимпийн наадамд зориулан бүтээсэн бүх бэлгэ тэмдгийг олимпийн эмблем гэж үзнэ. Уг эмблемийн хийцийг ЗБХ-ноос ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр батлуулахаар өргөн мэдүүлнэ. Уг бэлгэ тэмдэгийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс урьдчилан бичгээр зөвшөөрөл аваагүй ҮОХ-д болон улсуудад арилжааны зорилгоор хэрэглэгдэхгүй.

4. ЗБХ нь ОУОХ-ны олимпийн наадмын эмблем, бэлгэ тэмдгийн өмчийн эрхийг үндэсний болон олон улсын хэмжээнд хамгаалахийг батална. ЗБХороо нь ганцаараа зохион байгуулах хороо татан буугдсанаас хойш зохион байгуулагч улсын ҮОХ олимпийн наадмын бэлтгэл, зохион байгуулах үеэр, олимпийн наадам болсон жилийн эцэс дуусахаас өмнө эмблем, бэлгэ тэмдэг мөн түүнчлэн олимпийн наадамтай холбоотой марк, энгэрийн тэмдэг, зурагт хуудас, эд юмс, бичиг баримтийг бүрэн ашиглана. Эмблем, бэлгэ тэмдэг болон марк, хийц, энгэрийн тэмдэг, зурагт хуудас, эд юмс, бичиг баримт зэрэг бусад зүйлтэй холбоотой эрх уг хугацаа дуустал болон цаашид ОУОХ-нд хамаарна. ЗБХ эсвэл ҮОХ нь энэ тухайд ОУОХ-

ны эрх ашгийн үүднээс итгэмжлэгдсэн этгээдийн үүрэг гүйцэтгэнэ.

5. Энэхүү журмын заалтуудыг Чуулган болон Олимпийн конгрессын зохион байгуулах хороогоор үзэглэсэн бүх гэрээнд хэрэглэнэ.

6. Тамирчид, албаныханы дүрэмт хувцас өөрсдийн ҮОХ-ны далбаа, эмблем бүхий, ЗБХ-ны зөвшөөрлөөр олимпийн эмблемтэй байж болно.

ОУС-ын холбоодын албаныхан өөрсдийн холбоодын дүрэмт хувцсыг өмсч, эмблемийг зүүнэ.

7. Техник тоног төхөөрмж мөн цаг тоолох төхөөрөмж, онооны самбар зэрэг олимпийн наадамд оролцогч тамирчид болон бусад оролцогчдийн өмсөж, хэрэглэхээс бусад аппарат хэрэгслийн таниулга, шошго тэмдэг ямар ч тохиолдолд тоног төхөөрөмж, аппарат хэрэгслийн өндөрийн 1/10-ээс эсвэл өндрөөрөө 10 см-ээс хэтрэхгүй байна.

8. "Таниулга, шошго тэмдэг" гэдэг нь тухайн зүйлийг үйлдвэрлэгчийн нэр, худалдааны тэмдэг, лого, бусад ялгах тэмдгийг нэгээс олон харуулахгүйгээр ердийн байдлаар үзүүлснийг ойлгоно.

9. ЗБХ, олимпийн наадамд оролцогчид бүгд магадлан итгэмжлэгдсэн бусад бүх хүн, холбогдох бусад хүмүүс болон талууд дүрэм 50 ба энэхүү журамд заасан бүхий л зүйлд нийцүүлэн удирдамж, лавлах, ОУОХ-ноос гаргасан бусад зааварыг дагаж мөрдөнө.

IV. ПРОТОКОЛ

51. Протокол

1. Олимпийн наадмын хугацаанд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь бүх талбай, заал танхим, байгууламжинд ЗБХ-ны үүрэг хариуцлагын хүрээнд нийцэх протоколыг тодорхойлох эрхийг дангаараа эдэлнэ.

2. Олимпийн наадмын туршид олимпийн наадмын бүх үйл ажиллагаан дээр ОУОХ-ны гишүүд, хүндэт гишүүд, хүндэт ерөнхийлөгч нь тэдний албан тушаалын

эрэмбээр ерөнхийлөгч, хүндэт ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгчид тэргүүлэн араас нь ОНЗБХ-ны гишүүд, ОУСХ-дын ерөнхийлөгчид, ҮОХ-дын ерөнхийлөгчид гэсэн дараалалтай байна.

3. ОНЗБХ, ОУСХ-д, ҮОХ-д болон Олимпийн наадамд оролцож байгаа бүх итгэмжлэгдсэн хүмүүс ОУОХ-ны протокол, ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн бусад бүх заавар дүрэм журмыг хүндэтгэлтэйгээр дагаж мөрдөнө.

52. Олимпийн наадмын үнэмлэх, нэвтрэх зөвшөөрлийн карт

1. Олимпийн наадамд оролцох үнэмлэх, нэвтрэх зөвшөөрлийн карт нь түүнийг эзэмшигчийн Олимпийн наадамд оролцох эрхийг баталгаажуулсан бичиг баримт юм. Эзэмшигчийн паспорт эсвэл албан ёсны аялалд хүчин төгөлдөр өөр бичиг баримтын хамтаар наадмын үнэмлэх нь тухайн хүнийг наадам зохион байгуулагч улс, хотод нэвтрэх үндэслэл болно. Энэхүү бичиг баримт нь түүнийг эзэмшигчдээ Олимпийн наадмын туршид, наадмаас нэг сарын өмнө мөн наадмаас нэг сарын дараагаас илүүгүй хугацаанд тус газар оронд байж, Олимпод оролцох үйл ажиллагаагаа явуулах эрхийн боломжыг олгоно.

2. Олимпийн наадамд оролцох үнэмлэх, нэвтрэх зөвшөөрлийн картыг ОУОХ-ны зөвшөөрлөөр оролцох эрхийг авсан этгээдэд олгоно. Ингэхдээ тэдгээр оролцогчдод тодорхой хэм хэмжээнд, тодорхой талбай, заал танхимд болох үйл ажиллагаанд Олимпийн наадам ЗБХ-ны бүрэн хариуцлагын дор оролцох боломжыг бүрдүүлнэ. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс тухайн нэвтрэх зөвшөөрлийн картны үйл ажиллагааны эрх, хамрах хүрээ, олгогдох хүмүүс, зарчмуудыг тус тус тодорхойлно. ОНЗБХ, ОУСХ-д, ҮОХ-дын хүмүүс болон бусад холбогдох талууд бүхий л гарын авлага, бусад зааварчилгаа зэрэг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн дүрэм журамтай холбоотой мэдээлэлтэй танилцсан байх ёстой.

53. Олимпийн далбааг хэрэглэх нь

1. Бусад бүх туг далбаанаас том хэмжээтэй Олимпийн далбааг Олимпийн наадмын

туршид наадмын төв стадионд өндөрлөг тусгай талбайд болон бусад заал танхимуудад байршуулан намируулах ёстой ба энэ ажиллагааг Олимпийн наадмыг ЗБХ бүрэн хариуцна. Энэ далбаа нь Олимпийн наадмын нээлтийн ёслолын ажиллагаагаар өргөгдөж, хаалтын ёслолоор бууна.

2. Олимпийн хотхонд болон уралдаан тэмцээн, бэлтгэл сургуулилтын заал танхим зэрэг буй бүхий л газарт Олимпийн далбааг намируулах ёстой бөгөөд эдгээрийг Олимпийн наадамыг ЗБХ бүрэн хариуцана намируулах үүрэгтэй.

54. Олимпийн галыг хэрэглэх нь

1. ОНЗБХ нь олимпийн галыг олимпийн цэнгэлдэх хүрээлэнд авчрах үүрэг хүлээнэ. Галт бамбарыг буухиачлан авчрах, олимпийн галыг хэрэглэх бүх бэлтгэлийг ОУОХ-ны протоколын удирдамжид ягштал нийцүүлэн хангана.
2. Олимпийн наадмын хаалтын ёслолын арга хэмжээний дараа олимпийн бамбар, тогоо, олимпийн гал асаахад зориулагдсан бусад тоног төхөөрмж зэргийг ОУОХ-ны зөвшөөрөлгүйгээр зохион байгуулагч хотод эсвэл өөр хаа нэгтээ хэрэглэхийг хориглоно.

55. Нээлт болон хаалтын ажиллагаа

1. Олимпийн наадмын нээлт, хаалтын ёслолын арга хэмжээг ОУОХ-ны протоколд ягштал нийцүүлэн зохион байгуулна.
2. Ёслолын арга хэмжээний бүхий л үзүүлбэр, тоглолтууд, хөтөлбөр, цагийн хуваарь зэргийг урьдчилан ОУОХ-гоор батлуулна.
3. Олимпийн наадам нь тухайн Олимпийн наадмыг зохион байгуулагч орны Төрийн тэргүүний нээлтээр эхлэх бөгөөд дараахь өгүүлбэрийг хэрэглэнэ:
 - Олимпийн наадмын Нээлтийн үе бол:
“ Би орчин цагийн ...(наадмын дугаарыг хэлэх) (зохион байгуулж буй хотын нэрийг хэлэх)”...наадмыг нээснийг мэдэгдэж байна гэх
 - Хэрэв өвлийн олимпийн нээлт бол:

“ Би (Өвлийн Олимпийн наадмын дугаарыг)...(зохион байгуулж байгаа хотын нэрийг) нээснийг мэдэгдэж байна гэх мэт”

Олимпийн наадмын үеэр ОНЗБХ-ны бэлтгэсэн заал танхим, байгууламжинд болох бүхий л арга хэмжээнд аливаа улс төрч, засаг захиргааны, олон нийтийн албан тушаалтан хэн ч ямар ч асуудал сэдвээр аливаа мэдэгдэл хийх үг хэлэх эрхгүй бөгөөд, зөвхөн нээлтийн болон хаалтын ёслолын үеэр Олимпийн наадмыг ЗБХ-ны ерөнийлөгч болон ОУОХ ны тэргүүн богино товч мэдэгдэл хийнэ.

56. Диплом, медаль, шагнал гардуулах ёслолын ажиллагаа

Ялалтын туг мандуулах, медаль, диплом гардуулах ёслолыг ОУОХ-ны протколд заасны дагуу нарийн дэгтэйгээр явуулна.

Медалийн болон дипломны загвар хийцийг ОУОХ-нд урьдчилан өргөн барьж батлуулсан байна.

57. Шагналтнуудын нэрсийн жагсаалт

ОУОХ болон ОНЗБХ нь улс тус бүрээр шагналтуудыг эрэмбэлэн жагсаах ёсгүй. Спортын төрөл тус бүртээ медал, дипломын болзол хангасан тамирчдын нэрсийг ОНЗБХ хариуцан бүртгэж, медал авсан тамирчдын нэрс төв цэнгэлдэх хүрээлэнд байрлах самбарт хүндэтгэлтэйгээр харагдах ёстой.

58. ОУОХ - эрх мэдэл

Олимпийн наадамтай холбоотой аливаа асуудал ОУОХ-ны эрх мэдэлд шилжинэ.

6. Арга хэмжээ, шийтгэл, сахилгын дүрэм, маргаан шийдвэрлэх

59. Арга хэмжээ, шийтгэл*

Олимпын харт, Олон улсын сэргээшийн эсрэг дүрэм, болон бусад дүрэм журам зөрчигдсөн тохиолдолд асуудлыг дүрмийн доорхи 2.4-т зааснаар Чуулган, ОУОХ-н гүйцэтгэх хороо болон сахилгын хороо дараахь байдлаар зөвшилцөн зохих арга хэмжээг авна:

1. Олимпийн хөдөлгөөний хүрээнд:

1.1 ОУОХ-ны гишүүд, Хүндэт ерөнхийлөгч, хүндэт гишүүд болон өргөмжит гишүүдэд хамаарна:

а) сануулах, донгодох арга хэмжээг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргана;

б) хугацаа заан түдгэлзүүлэх ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргана.

Түдгэлзүүлэх нь тухайн хүний гишүүний бүрэн эрх дарх болон үүргийг бүгдийг болон хэсэгчлэн хязгаарлаж болно.

Дээр дурдсан шийтгэлүүдийг хавсарч хэрэглэж болно. ОУОХ-ны гишүүд, Хүндэт ерөнхийлөгч, хүндэт гишүүд, өргөмжит гишүүд хэн байлаа ч ОУОХ-ны ашиг сонирхол Олимпийн хартын дүрэм журмыг ямар хэмжээнд зөрчсөнөөс үл хамааран шийтгэл хүлээнэ.

Арга хэмжээ, шийтгэл, сахилгын дүрэм, маргаан шийдвэрлэх

1.2 ОУС-ын холбоодод хамаарна:

а) Олимпийн наадмын хөтөлбөрөөс хасах:

- Спорт (Чуулган),
- Төрөл (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл),
- Тэмцээн (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл);

б) Нөхцөлт түр хүлээн зөвшөөрлийг цуцлах (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл);

с) Бүрэн хүлээн зөвшөөрлийг цуцлах (Чуулган).

1.3 ОУС-ын холбоодын зөвлөл, нэгдэлд хамаарна:

а) Нөхцөлт түр хүлээн зөвшөөрлийг цуцлах (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл);

б) Бүрэн хүлээн зөвшөөрлийг цуцлах (Чуулган).

1.4 ҮОХороодод хамаарна:

а) Түр эрх хасах (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл); Тухайн үйл ажиллагаанд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл асуудал үүссэн ҮОХ болон тэдний тамирчид хамаарагдах эсэхийг тогтооно;

б) Нөхцөлт түр хүлээн зөвшөөрлийг цуцлах (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл);

с) Бүрэн хүлээн зөвшөөрлийг цуцлах (Чуулган); ийм нөхцөлд, ҮОХ-ны Олимпын харттай холбоотой бүх эрх мэдэл дуусгавар болно;

д) Чуулган эсвэл олимпийн конгресийг зохион байгуулах эрхийг цуцлах (Чуулган).

1.5 ҮОХороодын зөвлөл нэгдэлд хамаарна:

а) Нөхцөлт түр хүлээн зөвшөөрлийг цуцлах (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл);

б) Бүрэн хүлээн зөвшөөрлийг цуцлах (Чуулган).

1.6 Зохион байгуулагч хот, ЗБХ, ҮОХ-нд хамаарна:

Олимпийн наадмыг зохион байгуулах эрхийг цуцлах (Чуулган).

1.7 Хүсэлт гаргагч буюу нэр дэвшигч хотууд, ҮОХ-нд хамаарна:

Олимпийн наадмыг зохион байгуулахаар хүсэлт гаргагч буюу нэр дэвшигч хотын эрхийг цуцлах (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл).

1.8 Бусад хүлээн зөвшөөрөгдсөн зөвлөл, байгууллагуудад хамаарна:

а) Нөхцөлт түр хүлээн зөвшөөрлийг цуцлах (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл);

b) Бүрэн хүлээн зөвшөөрлийг цуцлах (Чуулган).

2. Олимпын наадмын үеэр Олимпын харт, Олон улсын сэргээшийн эсрэг дүрэм, ОУОХ-ны ёс зүйн дүрэм, ОУОХ, ОУСХ, ҮОХ-ноос гаргасан нийтээр хүлээн зөвшөөрсөн журам, бусад шийдвэр, ёс зүйн хууль зэрэг зөрчигдсэн ёс бус үйлдлийн аливаа илрэл тохиолдолдвол:

2.1 Ганцаарчилсан тамирчид болон багуудад хамаарна: түр болон бүр мөсөн эрхийг Олимпийн наадмаас хасах, бүртгэлээс хасах, магадлан итгэмжлэлийг цуцлах; тэмцээнд тоглох эрхийг хасах буюу тэмцээнээс хасах тохиолдолд олимпийн хартийг зөрчин байж авсан медаль, үнэмлэхийг ОУОХ-нд эргүүлэн өгнө. Мөн ОУОХ үзэмжээр олимпийн наадамд тоглох эрхээ хасуулсан буюу хасагдсан тамирчин ба багийн олимпийн наадмын бусад тэмцээнээс авсан чансааг хүчингүй болгож, хэрэв медаль, диплом авсан бол ОУОХ буцааж авна.

2.2 Албаныхан, менежер, төлөөлөгчид болон багийн бусад гишүүд, мөн түүнчлэн шүүгчид, шүүгчдийн бүрэлдхүүний гишүүдэд хамаарна: түр болон бүр мөсөн эрхийг нь хасах эсвэл олимпийн наадмаас хасах (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл);

2.3 бусад бүх магадлан итгэмжлэгдсэн, нэвтрэх эрхийн үнэмлэхтэй хүмүүст хамаарна: Магадлан итгэмжлэлийг цуцална (ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл);

2.4 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь өөрийн эрхийг сахилгын хороонд шилжүүлж болно.

3. Арга хэмжээ шийтгэл оногдуулахаасаа өмнө ОУОХ-ны эрх бүхий байгууллагаас анхааруулга өгч болно.

4. Арга хэмжээ, шийтгэлийг ОУОХ, ҮОХороод, ОУСХ-д болон бусад этгээдийн эрхийг зөрчихгүйгээр оногдуулна.

Арга хэмжээ, шийтгэл, сахилгын дүрэм, маргаан шийдвэрлэх

Дүрмийн 59-т хамаарах заалтууд

1. Аливаа хоригийн хэм хэмжээг зөрчсөн баримтыг шалгах нь ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөлийн бүрэн эрхэд хамаарах бөгөөд гүйцэтгэх зөвлөл нь энэ эрхээ бүхэлд нь эсвэл хэсэгчлэн шилжүүлж болно.
2. ОУОХ-ны гүйцэтгэх зөвлөл тухайн хувь хүн, байгууллагатай холбоотой асуудлыг нягтлан үзээд уг байгууллага, хувь хүний гишүүнчлэл, статусын эрхийг хэсэгчлэн болон бүхэлд нь хураан авч болно.
3. Ганцаарчилсан, багаар тэмцээнд оролцож буй тамирчид болон хувь хүн иргэн, хуулийн этгээд нь ОУОХ-ны эрх бүхий байгууллагаас тэд нарт оноосон шийтгэл арга хэмжээг сонсож, мэдэж болно. Өөрсддөө оногдсон шийтгэл арга хэмжээг сонсоод үүний эсрэг биечлэн болон бичгээр зарга үүсгэх өргөдлөө өргөн барьж болно.
4. Чуулган, ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөл эсвэл сахилгын хорооноос дүрмийн 59.2.4-д заасан аливаа арга хэмжээ, шийтгэлийг оногдуулахдаа холбогдох талд заавал бичгээр мэдэгдэнэ.
5. Эрх бүхий этгээд өөрөөр шийдвэрлээгүй тохиолдолд бүх авсан арга хэмжээ, шийтгэл нэн даруй хүчин төгөлдөр болно.

60. ОУОХ-ны шийдвэрийг давж заалдах нь*

Тухайн Олимпийн наадмын тэмцээн уралдаан, түүний дүн болон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дүрэм журам, олон улсын сэргээшийн эсрэг дүрэмийн заалтууд, арбитруудын товлосон цаг хугацаа болон даваж заалдах журмын талаар ОУОХ нь ямар нэгэн шийдвэрийг гаргахгүй. Харин хэн ч ОУОХ-ны эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэртэй давж заалдах боломжтой бөгөөд тухайн Олимпийн наадмын хаалтын ажиллагаа болсон өдрөөс гурван жилийн дараа зарга үүсгэж болно.

61. Маргаан шийдвэрлэх

1. Эцсийн шийдвэрийг ОУОХ гаргана. Хүсэлт, тайлбартай холбоотой аливаа маргааныг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр шийдвэрлэгдэнэ, гэхдээ зарим тохиолдолд Спортын арбитрийн шүүхэд арбитрчаар шийдвэрлүүлж болно.
2. Спорттой холбоотой арбитрийн дүрмийн дагуу Олимпийн наадамтай холбоотой үүссэн аливаа маргааныг зөвхөн спортын арбитрийн шүүхэд мэдүүлнэ.